



МОНГОЛ УЛСЫН ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР

САНХҮҮГИЙН АУДИТЫН ТАЙЛАН

МОНГОЛ УЛСЫН 2016 ОНЫ НЭГДСЭН ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛД ХИЙСЭН АУДИТ

Улаанбаатар хот

2017 оны 6 дугаар сар

Тайланг бэлтгэсэн:	Агуулга	
Үндэсний аудитын газрын Санхүүгийн аудитын газар	Товчилсон үгийн жагсаалт	2
Газрын захирал бөгөөд тэргүүлэх аудитор	Нэг. Ерөнхий зүйл	3
Ц.Наранчимэг	1.1 Аудитын зорилт, хамарсан хүрээ, арга зүй	3
Аудитын менежер	БҮЛЭГ 1. ТӨСВИЙН ТӨЛӨВЛӨЛТ	4
С.Оюунгэрэл	БҮЛЭГ 2. МОНГОЛ УЛСЫН 2016 ОНЫ НЭГДСЭН ТӨСӨВ	6
Ахлах аудитор	2.1 Нэгдсэн төсвийн нийт орлого ба тусламж	6
Д.Цэрэндорж Ж.Батсайхан	2.2 Нэгдсэн төсвийн нийт зарлага ба цэвэр зээл	8
Аудитор	2.3 Нэгдсэн төсвийн тэнцэл	13
Ш.Ичинхорлоо О.Баярмаа Ш.Отгонбаяр Ш.Гүрпүрэв Ц.Энхжаргал Д.Цэгмиддорж	2.4 Монгол Улсын Засгийн газрын өр	13
	БҮЛЭГ 3. МОНГОЛ УЛСЫН 2016 ОНЫ ТӨСӨВ	16
	3.1 Улсын төсвийн орлого	16
	3.2 Улсын төсвийн зарлага	19
	3.3 Улсын төсвийн тэнцэл	21
	БҮЛЭГ 4. ОРОН НУТГИЙН 2016 ОНЫ ТӨСӨВ	22
	4.1 Орон нутгийн төсвийн орлого	22
	4.2 Орон нутгийн төсвийн зарлага	23
	4.3 Орон нутгийн төсвийн тэнцэл	24
	БҮЛЭГ 5. ХҮНИЙ ХӨГЖИЛ САНГИЙН 2016 ОНЫ ТӨСӨВ	25
	5.1 Хүний хөгжил сангийн төсвийн орлого	25
	5.2 Хүний хөгжил сангийн төсвийн зарлага	25
	5.3 Хүний хөгжил сангийн төсвийн тэнцэл	25
2017 оны 6 дугаар сар	БҮЛЭГ 6. НИЙГМИЙН ДААТГАЛЫН САНГИЙН 2016 ОНЫ ТӨСӨВ	26
Уг тайланг ҮАГ-ын цахим хуудаснаас үзнэ үү:	6.1 Нийгмийн даатгалын сангийн төсвийн орлого	26
www.audit.mn	6.2 Нийгмийн даатгалын сангийн төсвийн зарлага	26
Аудитын тайлантай холбоотой асуудлаар нэмж тодруулах, асууж лавлах зүйлийн талаар 261663 дугаарын утсаар харилцана уу.	6.3 Нийгмийн даатгалын сангийн төсвийн тэнцэл	28
ХАЯГ:	БҮЛЭГ 7. НЭМЭЛТ ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ	29
Үндэсний аудитын газар Чингэлтэй дүүрэг, Засгийн газрын 4 дүгээр байр, Бага тойруу-3 Улаанбаатар-15160 Монгол Улс	ДҮГНЭЛТ	30
	Монгол Улсын Их Хурлын анхааралд толилуулах нь:	31
	ЗӨВЛӨМЖ	32
	Хавсралт №1	33
	Хавсралт №2	34
	Хавсралт №3	35
	Монгол Улсын Ерөнхий аудиторовын тушаал	36

Товчилсон үгийн жагсаалт

ААНБ	Аж ахуйн нэгж байгууллага
ААНОАТ	Аж ахуйн нэгжийн орлогын албан татвар
Ам.доллар	Америк доллар
АМНАТ	Ашигт малтмалын нөөц ашигласны төлбөр
БНХАУ	Бүгд Найрамдах Хятад Ард Улс
БСШУСС	Боловсрол, соёл, шинжлэх ухаан, спортын сайд
БХБС	Барилга, хот байгуулалтын сайд
БХС	Батлан хамгаалахын сайд
ДНБ	Дотоодын нийт бүтээгдэхүүн
ЗГҮЦ	Засгийн газрын үнэт цаас
ЗДТГ	Засаг даргын Тамгын газар
ЗТХС	Зам, тээврийн хөгжлийн сайд
ЖДҮДС	Жижиг, дунд үйлдвэрлэлийг дэмжих сан
ИНЕГ	Иргэний нисэхийн ерөнхий газар
ИТХ	Иргэдийн Төлөөлөгчдийн Хурал
НДС	Нийгмийн даатгалын сан
НЗДТГ	Нийслэлийн Засаг даргын Тамгын газар
НӨАТ	Нэмэгдсэн өртгийн албан татвар
НДШ	Нийгмийн даатгалын шимтгэл
мян.тн	мянган тонн
ОАТ	Онцгой албан татвар
ОНХНС	Орон нутгийн хөгжлийн нэгдсэн сан
ӨҮЦ	Өнөөгийн үнэ цэнэ
ТББ	Төрийн бус байгууллага
ТЕЗ	Төсвийн ерөнхийлөн захирагч
ТЗШ	Тусгай зориулалтын шилжүүлэг
ТӨХК	Төрийн өмчит хувьцаат компани
ТУЗ	Төлөөлөн удирдах зөвлөл
ТХМ	Төсвийн хүрээний мэдэгдэл
ТЭДС	Тариалан эрхлэлтийг дэмжих сан
тбм төг	тэрбум төгрөг
тн	тонн
УИХ	Улсын Их Хурал
ҮАГ	Үндэсний аудитын газар
ҮОМШӨ	Үйлдвэрийн осол, мэргэжлээс шалтгаалах өвчин
ХХААХҮС	Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн сайд
ХНХС	Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайд
ХЗДХС	Хууль зүй, дотоод хэргийн сайд
ХК	Хувьцаат компани
ХХС	Хүний хөгжил сан
ХХОАТ	Хувь хүний орлогын албан татвар
ХХК	Хязгаарлагдмал хариуцлагатай компани
ЦТС	Цахилгаан түгээх сүлжээ
ЭХС	Эрчим хүчний сайд

Нэг. Ерөнхий зүйл

1.1 Аудитын зорилт, хамарсан хүрээ, арга зүй

Үндэсний аудитын газар Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.10.2¹ дахь заалтын дагуу Монгол Улсын 2016 оны нэгдсэн төсвийн гүйцэтгэлд 2017 оны 5 дугаар сарын 10-наас 6 дугаар сарын 2-ны хугацаанд аудит хийв.

Аудитын зорилт

Монгол Улсын 2016 оны нэгдсэн төсвийн гүйцэтгэл үнэн зөв илэрхийлэгдсэн эсэх талаар үндэслэлтэй баталгаагаар хууль тогтоох байгууллагыг хангахад энэхүү аудитын зорилт чиглэгдлээ.

Хамарсан хүрээ

Сангийн яам Төсвийн тухай хуулийн 12 дугаар зүйлийн 12.1.7²-д заасны дагуу Монгол Улсын 2016 оны нэгдсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан, танилцуулгыг дараах бүрэлдэхүүн хэсэг, дараалалтай тайлагнажээ. Үүнд:

- Монгол Улсын 2016 оны нэгдсэн төсвийн гүйцэтгэл
- Монгол Улсын 2016 оны төсвийн гүйцэтгэл
- Хүний хөгжил сангийн 2016 оны төсвийн гүйцэтгэл
- Нийгмийн даатгалын сангийн 2016 оны төсвийн гүйцэтгэл
- Орон нутгийн төсвийн 2016 оны гүйцэтгэл
- Монгол Улсын Засгийн газрын өрийн талаарх танилцуулга

Танилцуулгын хавсралт мэдээлэлд:

- Монгол Улсын 2016 оны нэгдсэн төсвийн үр дүнгийн үзүүлэлт
- Улсын төсвийн ерөнхийлөн захирагчдын 2016 оны төсвийн гүйцэтгэл
- Хөрөнгө оруулалтын төсөл арга хэмжээний гүйцэтгэл
/Улсын төсөв, Хөгжлийн банк, Вексель, Концессын эх үүсвэр тус бүрээр/
- Засгийн газрын нөөц сангийн гүйцэтгэл
- ХХС, НДС, Орон нутгийн төсвийн гүйцэтгэл
- Засгийн газрын өрийн үзүүлэлтүүд, гадаад зээлээр хэрэгжүүлсэн төсөл, хөтөлбөр
- Худалдан авах ажиллагааны тайлан
- Татварын зарлагын тайлан
- 2016 оны нэмэлт төсвийн зарлагын гүйцэтгэлийн тайлан
- ТЭЗ-дын 2016 онд хэрэгжүүлсэн хөтөлбөр, хөтөлбөрийн үр дүнгийн талаарх чанарын болон тоо хэмжээний үзүүлэлтийн тайлангийн нэгтгэлийг тус тус толилуулсан байна.

Арга зүй, стандартын талаарх мэдэгдэл

Аудитын олон улсын стандарт, Санхүүгийн болон Гүйцэтгэлийн аудитын гарын авлага, Монгол Улсын Ерөнхий аудиторов баталсан төлөвлөгөө, хөтөлбөрийн дагуу аудитыг гүйцэтгэсэн бөгөөд Сангийн яам болон бусад холбогдох яам, байгууллагын албан тушаалтнуудтай ярилцлага хийх, судалгаа авах, дансны хуулгатай тулган баталгаажуулах, тоон мэдээлэл авах, дүн шинжилгээ хийх зэрэг аудитын арга зүйг ашиглаж, аудитын дүн, дүгнэлтэд үндэслэн зөвлөмжийг боловсруулав.

Нэгдсэн төсвийн 2016 оны гүйцэтгэлийн аудитын тайланд Орон нутгийн төсвийн гүйцэтгэлд нэгдсэн удирдамжаар хийсэн аудитын дүнг нэгтгэлээ. Түүнчлэн улсын төсвийн хөрөнгө оруулалтын гүйцэтгэлд тусад нь аудит хийсэн тул уг тайланд оруулаагүй болно.

Аудитын нотлох зүйлс, холбогдох мэдээ судалгааг ажлын баримт материалд хавсаргав.

¹ "төрийн аудитын төв байгууллага нэгдсэн төсвийн гүйцэтгэл, Засгийн газрын санхүүгийн нэгтгэсэн тайланд нэг сарын дотор аудит хийж, Засгийн газар, Улсын Их Хуралд хүргүүлэх"

² "нэгдсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан гаргах"

БҮЛЭГ 1. ТӨСВИЙН ТӨЛӨВЛӨЛТ

1.1.1. Монгол Улсын тухайн жилийн нэгдсэн төсвийн төслийг боловсруулах, батлах харилцааг Төсвийн тогтвортой байдлын тухай болон Төсвийн тухай хуулиар зохицуулж байна.

1.1.2. Улсын Их Хурлаас Төсвийн тогтвортой байдлын тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.1.1-д “дунд хугацааны төсвийн хүрээний мэдэгдлийг ... төсвийн тэнцвэржүүлсэн орлогын хэмжээ, төсвийн тусгай шаардлагад нийцүүлж хуульчлан батлах” гэж заасны дагуу Монгол Улсын нэгдсэн төсвийн 2016 оны төсвийн хүрээний мэдэгдэл, 2017-2018 оны төсвийн төсөөллийн тухай хуулийг анх 2015 оны 5 дугаар сарын 21-нд баталж, нэгдсэн төсвийн 2016 оны төслийг боловсруулахад баримтлах чиглэлийг тогтоожээ.

1.1.3. Үүний дараа дээрх хуульд 2 удаа нэмэлт өөрчлөлт оруулан баталсан бөгөөд эдгээрийг хүснэгтээр харуулбал:

/Хүснэгт №1/

Эдийн засгийн үндсэн үзүүлэлт	Төсвийн хүрээний мэдэгдэл			Өөрчлөлт /өмнөх түвшнээс/	
	Анх баталсан /2015.05.21/	Нэмэлт өөрчлөлт-1 /2015.11.13/	Нэмэлт өөрчлөлт-2 /2016.09.09/	Нэмэлт өөрчлөлт-1	Нэмэлт өөрчлөлт-2
Нэгдсэн төсвийн тэнцвэржүүлсэн орлогын хэмжээ	6,642.0	7,013.9	5,348.2	371.9	(1,665.7)
1 /тбм.төг/					
- ДНБ-д эзлэх хувь	24.6	25.4	22.1	0.8	(3.3)
Нэгдсэн төсвийн нийт зарлагын дээд хэмжээ /тбм.төг/	7,722.8	7,954.4	9,694.4	231.6	1,740.0
2					
- ДНБ-д эзлэх хувь	28.6	28.8	40.1	0.2	11.3
Нэгдсэн төсвийн нийт зарлагын өсөлтийн хэмжээ	(114.6)	701.1	2,556.4	815.7	1,855.3
3 /тбм.төг/					
- ДНБ-д эзлэх хувь	(0.4)	2.5	10.6	2.9	8.1
Нэгдсэн төсвийн тэнцвэржүүлсэн тэнцэл /тбм.төг/	(1,080.8)	(940.5)	(4,346.2)	(140.3)	3,405.7
4					
- ДНБ-д эзлэх хувь	(4.0)	(3.4)	(18.0)	(0.6)	14.6
Нэгдсэн төсвийн хөрөнгийн зардлын хэмжээ /тбм.төг/	1,453.9	1,930.5	2,350.0	476.6	419.5
5					
- ДНБ-д эзлэх хувь	5.4	7.0	9.7	1.6	2.7
Засгийн газрын өрийн нийт хэмжээ ӨҮЦ-ээр /тбм.төг/	14,861.3	15,174.4	21,299.1	313.1	6,124.7
6					
- ДНБ-д эзлэх хувь	55.0	55.0	88.0	0.0	33.0
Нийгмийн халамжийн тухай хуульд заасны дагуу төсвөөс санхүүжих зардлын нийт хэмжээ /тбм.төг/	303.5	295.2	294.9	(8.3)	(0.3)
7					
- ДНБ-д эзлэх хувь	1.1	1.1	1.2	0.0	0.1

1.1.4. Хүснэгтээс үзвэл, 16 сарын хугацаанд ТХМ-ээрх эдийн засгийн үндсэн үзүүлэлтүүдийн нэрлэсэн дүнг их хэмжээний хэлбэлзэлтэй буюу нэгдсэн төсвийн тэнцвэржүүлсэн орлого, нийгмийн халамжийн зардлаас бусад үзүүлэлтийг өмнөх түвшнээс 231.6-6,124.7 тэрбум төгрөгөөр нэмэгдүүлэн баталжээ.

1.1.5. Төсвийн төслийг боловсруулж батлахдаа өмнө батлагдсан дунд хугацааны ТХМ-ийг баримтлахгүйгээр тухайн нөхцөл байдалд тохируулан өөрчилж байгаа нь Төсвийн тогтвортой байдлын тухай хуульд заасан төсвийн төсөл боловсруулахад баримтлах шаардлагад нийцэхгүй байна.

1.1.6. Аймаг, нийслэлийн ИТХ нь орон нутгийн төсвийг батлахдаа Төсвийн тухай хуулийн 34 дүгээр зүйлийн 34.2.1³, 34.2.2⁴, 57.2⁵ дахь заалтыг мөрдөхгүйгээр аймаг, нийслэлийн төсвийг 2-5 удаа тодотгож, 2016 оны төсвийг анх батлагдсан дүнгээс орон нутгийн төсвийн нийт орлогыг 146.9 тэрбум төгрөг буюу 7.2 хувиар, нийт зарлагыг 439.5 тэрбум төгрөг буюу 22.0 хувиар нэмэгдүүлж, зарим орон нутгийн төсвийг алдагдалтай байхаар баталсан байна.

³ “дээд шатны төсөвт тодотгол хийсний улмаас тухайн шатны төсөвт тодотгол хийх зайлшгүй шаардлага бий болсон”

⁴ “урьдчилан тооцох боломжгүй нөхцөл байдлын улмаас төсвийн орлого буурах, зарлага нэмэгдэж, орон нутгийн төсөв алдагдалтай болох нөхцөл байдал бий болсон”

⁵ “орон нутгийн төсвийг алдагдалгүй төлөвлөн баталж, хэрэгжүүлнэ”

1.1.7. Аймаг, нийслэлийн ИТХ нь орон нутгийн төсөвт тодотгол хийхдээ орон нутгийн төсвийн алдагдлыг нийт 216.8 тэрбум төгрөгөөр нэмэгдүүлэн баталсан нь Монгол Улсын 2016 оны нэгдсэн төсвийн алдагдлыг УИХ-аар батлагдсан түвшнээс өсөхөд нөлөөлсөн байна.

1.1.8. Нийгмийн халамжийн тэтгэвэр, тэтгэмжийн зардлын төлөвлөлт нь тооцоо, судалгаа хангалтгүй хийгдсэнээс зарим орон нутагт тус сангийн мөнгөн хөрөнгө их хэмжээний үлдэгдэлтэй гарч, орон нутгийн үндсэн тэнцлийн ашигт тооцогдон бусад зардлын эх үүсвэрт зарцуулагдах нөхцөлийг бүрдүүлж байна. Тухайлбал, 2016 оны эцсийн байдлаар нийгмийн халамжийн санд Архангай 0.8 тэрбум, Баянхонгор 0.3 тэрбум, Орхон 0.6 тэрбум, Хөвсгөл 1.2 тэрбум, Баян-Өлгий 0.6 тэрбум, Говьсүмбэр 0.3 тэрбум төгрөг тус тус зарцуулагдаагүй үлджээ.

1.1.9. Иймд макро эдийн засгийн дунд хугацааны төсөөлөл, гадаад, дотоод хүчин зүйлсийг үндэслэлтэй тооцоолж, дунд хугацаанд баримтлах төсвийн хүрээний мэдэгдэлд нийцүүлж, бүх шатны төсвийн төслийг боловсруулах, төсөвт нэмэлт өөрчлөлт оруулахдаа батлагдсан хууль, суурь тооцооллыг өөрчлөх бус тууштай хэрэгжүүлэх шаардлагатай байна.

1.1.10. Монгол Улсын 2016 оны нэгдсэн төсвийн гүйцэтгэлийн тайланд төсвийн бүрэлдэхүүн хоорондын шилжүүлгийг 2,248.2 тэрбум төгрөгөөр төлөвлөснөөс гүйцэтгэлээр гарсан 2,228.2⁶ тэрбум төгрөгийн орлого, зарлагын гүйлгээг цэвэрлэж тайлагнасан байна.

⁶ ЭМД-ын сангаас улсын эмнэлгүүдэд олгосон татаас 174.7 тэрбум төгрөгөөр төлөвлөгдсөнөөс 170.8 тэрбум, Орон нутгаас улсын төсөвт төвлөрүүлсэн шилжүүлэг 92.3 тэрбум төгрөгөөр төлөвлөгдсөнөөс 90.7 тэрбум, Улсын төсвөөс орон нутгийн төсөвт олгосон тусгай зориулалтын болон ОНХНС-ийн шилжүүлэг, санхүүгийн дэмжлэг 1,277.6 тэрбум төгрөгөөр төлөвлөгдсөнөөс 1,266.5 тэрбум, НДШ-ийн зардал 208.7 тэрбум төгрөгөөр төлөвлөгдсөнөөс 205.3 тэрбум төгрөгийн гүйцэтгэл тус тус гарсан бол, Улсын төсвөөс НДС-д олгосон татаас 494.9 тэрбум төгрөгөөр төлөвлөгдөж бүрэн санхүүжигдсэн байна.

БҮЛЭГ 2. МОНГОЛ УЛСЫН 2016 ОНЫ НЭГДСЭН ТӨСӨВ

2.1 Нэгдсэн төсвийн нийт орлого ба тусламж

2.1.1 Нэгдсэн төсвийн 2016 оны нийт орлого ба тусламжийн дүнгийн анх батлагдсан төлөвлөгөөг 2015 оны гүйцэтгэлтэй⁷ харьцуулахад 1,038.9 тэрбум төгрөг буюу 17.4 хувиар нэмэгдүүлэн 7,022.3 тэрбум, тогтворжуулалтын санд төвлөрүүлэх орлогыг 8.4 тэрбум, нэгдсэн төсвийн тэнцвэржүүлсэн орлогыг 7,013.9 тэрбум төгрөгөөр тус тус тооцоолсон байна.

2.1.2 Төсвийн орлогын төлөвлөгөөнд зэс, алт, коксжих болон боловсруулсан чулуун нүүрсний зах зээлийн дундаж үнийг хүснэгтэд үзүүлснээр тооцож, уул уурхайн бүтээгдэхүүний борлуулалтаас орох татварын нийт орлогыг дараах байдлаар төлөвлөжээ.

/Хүснэгт №2/

№	Бүтээгдэхүүний нэр төрөл	Биет хэмжээ		Үнэ (ам.доллар/нэгж)		Нийт орлого (тбм.төг/)	
		Төлөв	Гүйц	Төлөв	Гүйц	Төлөв	Гүйц
1	Алт /тн/	13.5	16.6	1,156.0	1,243.6	62.2	61.6
2	Нүүрс /сая.тн/	19.5	25.8	32.8-54.8	28.3-77.0	133.5	142.3
3	Зэсийн баяжмал /мян.тн/	1,525.1	1,562.0	5,268.7	4,862.8	509.4	464.5
4	Цайрын баяжмал /мян.тн/	95.0	126.0	2,200.0	2,090.3	31.1	34.3
5	Төмрийн хүдэр /сая.тн/	5,000.0	6,084.5	34.8-43.2	45.1-47.3	27.2	15.3
6	Жонш, жоншны баяжмал /мян.тн/	307.0	248.9	244.2	251.6	10.7	5.3
7	Бусад					28.8	40.7
НИЙТ ДҮН						802.9	764.0

2.1.3 Тайлант онд уул уурхайн салбараас 802.9 тэрбум төгрөг төвлөрүүлэхээр төлөвлөсөн боловч зэсийн баяжмалын олон улсын зах зээлийн үнийн бууралтаас шалтгаалан төсөвт 764.0 тэрбум төгрөгийн орлого төвлөрчээ. Уул уурхайн салбараас 2016 онд төвлөрүүлсэн нийт орлогын 79.4 хувийг зэс, нүүрсний салбарын орлого эзэлж байна. Үүний 18.6 хувь буюу 142.3 тэрбум төгрөг нь нүүрс, 60.8 хувь буюу 464.5 тэрбум төгрөг нь зэсийн үйлдвэрлэлээс төвлөрсөн байна.

/график №1/



/график №2/



2.1.4 Тайлант онд “Оюутолгой” ХХК 197.7 мянган тн цэвэр зэс, 9.8 тн алт, 43.9 тн мөнгө агуулсан 904.6 мянган тн зэсийн баяжмал үйлдвэрлэн борлуулж 346.7 тэрбум, “Эрдэнэт үйлдвэр” ХХК 139.5 мянган тн цэвэр зэс, 44.1 тн мөнгө агуулсан 657.4 мянган тн зэсийн баяжмал үйлдвэрлэн борлуулж 117.7 тэрбум төгрөгийн татвар⁸-ыг тус тус төсөвт төвлөрүүлжээ.

2.1.5 Төсөвт төвлөрүүлсэн татварын орлогыг өмнөх онтой харьцуулахад “Оюутолгой” ХХК 179.6 тэрбум, “Эрдэнэт үйлдвэр” ХХК 207.1 тэрбум төгрөгөөр тус тус буурсан байна.

⁷ Нэгдсэн төсвийн нийт орлого ба тусламжийн 2015 оны гүйцэтгэл 5,983.4 тэрбум төгрөг байсан.

⁸ Сангийн яам, Татварын ерөнхий газрын мэдээлэлд суурилан тооцоолов.

2.1.6 Монгол Улсын төсвийн орлогод уул уурхайн салбарын эзлэх хувь 2011 онд 28.0 хувь байснаас 2016 онд 13.1 хувьтай тэнцэж, 14.9 пунктээр буурсан нь зэсийн баяжмал, нүүрс, цайрын баяжмал, төмрийн хүдэр, жонш зэрэг эрдэс бүтээгдэхүүний үнийн бууралтаас шалтгаалсан байна.

2.1.7 Нийт уул уурхайн орлогод нүүрсний салбараас төвлөрүүлэх орлогын эзлэх хувь 2011 онд 35.0 хувь байсан бол энэ үзүүлэлт сүүлийн жилүүдэд тасралтгүй буурч, 2016 онд 18.6 хувьд хүрсэн нь нүүрсний үнэ жил бүр буурч байгаатай холбоотой байна. Зэсийн баяжмалын экспортын биет хэмжээ өмнөх оноос 6.1 хувиар өсч, 2016 онд зэсээс төвлөрөх орлогын хэмжээ нийт уул уурхайн орлогын 60.8 хувийг бүрдүүлжээ.

2.1.8 УИХ 2016 онд улсын төсөвт 2 удаа тодотгол хийж, 2016 оны 9 дүгээр сарын 9-ний өдрийн хуулиар нэгдсэн төсвийн нийт орлогыг анх батлагдсанаас 1,593.2 тэрбум төгрөгөөр бууруулж, 5,429.1 тэрбум төгрөгөөр тодотгон баталсан байна.

/Хүснэгт №3/

/тэрбум төгрөг/

		2016 он					
д/д	Төсвийн орлогын ангилал	2015 оны гүйцэтгэл	Анх батлагдсан төсөв	Тодотгосон төсөв	Гүйцэтгэл	Зөрүү	Хувь
НИЙТ ОРЛОГО БА ТУСЛАМЖИЙН ДҮН		5,983.4	7,022.3	5,429.1	5,835.0	405.9	107.5
ТОГТВОРЖУУЛАЛТЫН САН		2.3	8.4	0.0	0.0	0.0	0.0
НИЙТ ТЭНЦВЭРЖҮҮЛСЭН ОРЛОГО БА ТУСЛАМЖИЙН ДҮН		5,981.1	7,013.9	5,429.1	5,835.0	405.9	107.5
А. УРСГАЛ ОРЛОГО		5,981.1	7,013.9	5,429.1	5,835.0	405.9	107.5
I.	ТАТВАРЫН ОРЛОГО	5,119.0	5,539.0	4,532.4	4,950.9	418.5	109.2
II.	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	862.1	1,474.9	896.7	884.1	-12.6	98.6
	Нийтлэг татварын бус орлого	753.6	934.1	770.9	805.4	34.5	104.5
	Хөрөнгийн орлого	55.1	172.4	13.7	1.5	-12.2	10.9
	Тусламжийн орлого	53.4	368.4	112.1	77.2	-34.9	68.9

Эх сурвалж: Сангийн яамны мэдээллээс авав.

2.1.9 Монгол Улсын нэгдсэн төсвийн тэнцвэржүүлсэн орлогын гүйцэтгэл 2016 онд 5,835.0 тэрбум төгрөгт хүрч, анх батлагдсан төсвөөс 16.8 хувь буюу 1,178.9 тэрбум төгрөгөөр дутуу, тодотгосон төсвөөс 7.5 хувь буюу 405.9 тэрбум төгрөгөөр илүү биелсэн бол өмнөх оны гүйцэтгэлээс 2.4 хувь буюу 146.1 тэрбум төгрөгөөр дутуу төвлөрсөн байна.

2.1.10 Нэгдсэн төсвийн нийт орлого ба тусламжийн 2016 оны гүйцэтгэлийг орлогын нэр төрлөөр гаргаж, Хавсралт №1-д үзүүлэв.

2.1.11 Нэгдсэн төсвийн нийт тэнцвэржүүлсэн орлогын 84.8 хувь нь татварын, 15.2 хувь нь татварын бус орлогоос тус тус бүрдэж байгаа бөгөөд татварын орлогын ДНБ-д эзлэх хувь хэмжээг харуулбал:

/Хүснэгт №4/

ҮЗҮҮЛЭЛТ	2012	2013	2014	2015	2016
ДНБ, оны үнээр /тэрбум.төг/	14,012.0	17,550.2	21,937.2	23,166.8	23,886.4
Татварын орлого /тэрбум.төг/	4,203.3	5,072.8	5,157.0	5,119.0	4,950.9
Татварын ачаалал, %	30.0	28.9	23.5	22.1	20.7

2.1.12 Хүснэгтээс үзэхэд, 2016 онд ДНБ-ийн хэмжээ 2012 оноос 9,874.4 тэрбум төгрөг, өмнөх оноос 719.6 тэрбум төгрөгөөр тус тус өсч, харин ДНБ-д эзлэх татварын ачаалал 20.7 хувьтай байгаа нь 2012 оныхоос 9.3, 2015 оныхоос 1.4 пунктээр тус тус буурчээ.

2.1.13 2016 онд татварын орлого 4,950.9 тэрбум төгрөгт хүрч, төлөвлөсөн орлогоос 9.2 хувиар буюу 418.5 тэрбум төгрөгөөр давж биелсэн байна. Тухайлбал, Орлогын албан татвар 88.1 тэрбум, нийгмийн даатгалын шимтгэл, хураамж 60.9 тэрбум, хөрөнгийн албан татвар 5.8 тэрбум, НӨАТ 59.3 тэрбум, онцгой албан татвар 98.3 тэрбум, тусгай зориулалтын орлого 2.2 тэрбум, гаалийн албан татвар 26.3 тэрбум, бусад татвар (төлбөр, хураамж) 77.6 тэрбум төгрөгөөр тус тус давж, татварын орлого бүх нэр төрлөөр биелжээ.

2.1.14 Тайлант онд татварын орлого анх 5,539.0 тэрбум төгрөгөөр батлагдсан боловч УИХ-ын 2016 оны 9 дүгээр сарын 9-ний өдрийн хуулиар 18.2 хувиар буюу 1,006.6 тэрбум төгрөгөөр бууруулан 4,532.4 тэрбум төгрөгөөр баталсан нь татварын нийт орлогын гүйцэтгэл 9.2 хувь, зарим төрлийн татварын орлого 15.4-25.6 хувиар давж биелэхэд нөлөөлсөн байна.

2.1.15 Төсвийн орлогын төлөвлөгөө давж биелсэн нь 2016 оны эхний 7 сарын гүйцэтгэлд тулгуурлан төсвийн тодотголоор орлогын төлөвлөгөөг бууруулан тооцож баталсан боловч тайлант оны сүүлийн улиралд эрдэс бүтээгдэхүүний үнэ дэлхийн зах зээл дээр төлөвлөсөн хэмжээнээс өссөн, экспортын биет хэмжээ нэмэгдсэн, татварын өрийн үлдэгдэл буурсан зэргээс шалтгаалсан байна.

2.1.16 Татварын бус орлого 884.1 тэрбум төгрөгт хүрч, төлөвлөснөөс 12.6 тэрбум төгрөгөөр дутуу буюу 98.6 хувийн гүйцэтгэлтэй байна. Үүнд: Хувьцааны ногдол ашиг 67.2 хувь буюу 8.8 тэрбум, төсөвт байгууллагын өөрийн орлого 5.3 хувь буюу 15.4 тэрбум, хөрөнгийн орлого 10.9 хувь буюу 12.2 тэрбум, тусламжийн орлого 31.1 хувь буюу 34.9 тэрбум төгрөгөөр тус тус төлөвлөсөн дүнгээс тасарсан нь татварын бус орлогын гүйцэтгэлд нөлөөлжээ. Судалгааг хүснэгтээр харуулбал:

/Хүснэгт №5 /

/тэрбум төгрөг/


Д/д	Татварын бус орлогын төрөл	2015 оны		2016 он		
		Гүйц	Төлөв	Гүйц	Зөрүү	Хувь
1	Хувьцааны ногдол ашиг	11.8	13.1	4.3	(8.8)	32.8
2	Төсөвт байгууллагын өөрийн орлого	220.5	289.9	274.5	(15.4)	94.7
3	Хөрөнгийн орлого	55.1	13.7	1.5	(12.2)	10.9
4	Тусламжийн орлого	53.4	112.1	77.2	(34.9)	68.9

Эх сурвалж: Сангийн яамны тооцоололд суурилав.

2.1.17 Тайлант онд “Эрдэнэт үйлдвэр” ХХК, “Оюутолгой” ХХК-иас нийт 1,525.1 мянган тн зэсийн баяжмал борлуулахаар төлөвлөж, гүйцэтгэлээр 1,562.0 мянган тн зэсийн баяжмал борлуулсан боловч зэсийн зах зээлийн дундаж үнэ⁹ тэнцвэржүүлсэн үнээс¹⁰ дунджаар 5.3 хувиар доогуур байсан тул Тогтворжуулалтын санд орлого төвлөрөөгүй байна.

2.2 Нэгдсэн төсвийн нийт зарлага ба цэвэр зээл

2.2.1 Монгол Улсын нэгдсэн төсвийн 2016 оны нийт зарлагын дээд хэмжээг төсвийн хүрээний мэдэгдэлд анх төлөвлөснөөс 1,971.6 тэрбум төгрөг буюу 25.5 хувиар нэмэгдүүлж, дотоодын нийт бүтээгдэхүүний 40.1 хувьтай, төсвийн нийт зарлагын өсөлтийн хэмжээг 2,671.0 тэрбум төгрөгөөр нэмэгдүүлэн, дотоодын нийт бүтээгдэхүүний 10.6 хувьтай тэнцэхээр тодотгон баталсан байна. Графикаар харуулбал: /тэрбум төгрөг/



⁹ Зэсийн 2016 оны зах зээлийн дундаж үнэ 4,862.8 ам.доллар,

¹⁰ Зэсийн тэнцвэржүүлсэн үнийг 5,137.7 ам.доллараар тооцсон байна.

2.2.2 Тайлант хугацаанд макро эдийн засгийн үндсэн үзүүлэлтүүдийн төсөөлөлд өөрчлөлт орсон нь дунд хугацааны төсвийн хүрээний мэдэгдэлд тусгасан дээрх үзүүлэлтийг шинэчлэх шаардлага бий болжээ.

2.2.3 Үүнээс гадна төсвийн нэгдмэл байдлыг хангах зорилгоор төсвийн гадуур хэрэгжиж байсан төсөл хөтөлбөрийг төсвийн төсөлд тусгаж төлөвлөх бодлогыг хэрэгжүүлсэнтэй холбоотойгоор зарлагыг нэмэгдүүлсэн байна.

2.2.4 Монгол Улсын 2016 оны нэгдсэн төсвийн тайлангаарх нийт зарлага ба цэвэр зээлийн төлөвлөгдсөн дүн /9,992.2 тэрбум төгрөг/-г 2016 оны төсвийн хүрээний мэдэгдэл /9,694.4 тэрбум төгрөг/-тэй харьцуулахад 3.0 хувь буюу 297.8 тэрбум төгрөгөөр нэмэгдэж, төлөвлөгдсөн ДНБ-ийн 41.3 хувийг эзэлж байна.

2.2.5 Энэ нь орон нутгийн ИТХ-аас эцэслэн баталсан төсвийн нийт зарлага Сангийн яамны хянасан суурь зарлагаас 439.5 тэрбум төгрөгөөр илүү гарсантай холбоотой байна.

2.2.6 Гадаад, дотоодын эдийн засгийн нөхцөл байдлын улмаас эдийн засгийн идэвхжилт суларч, 2016 оны макро эдийн засгийн төсөөлөл буурах хандлагатай болсон, 2016 оны төсөв батлагдсанаас хойшхи хугацаанд УИХ-аар баталсан хууль эрх зүйн орчны өөрчлөлт, мөн Засгийн газраас гаргасан шийдвэр болон бусад хүчин зүйлийн улмаас төсвийн зарлага нэмэгдэж, нэгдсэн төсвийн нийт алдагдал ДНБ-ийн (20.6) хувьд хүрэх хандлагатай байсан нь 2016 оны төсөвт тодотгол хийх үндэслэл болсон гэж Сангийн яам үзжээ.

2.2.7 УИХ-ын 2016 оны 7 дугаар сарын 21-ний өдрийн хуралдаанаар УИХ-ын 2016 оны ээлжит сонгуулийн үр дүнд шинээр байгуулагдсан Засгийн газрын бүтэц, бүрэлдэхүүнийг баталсантай холбогдуулан дээрх хүчин зүйлсийг 2016 оны төсөвт тусгах шаардлагатай байсны улмаас 2016 оны төсвийн тухай хуульд нэмэлт өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг боловсруулжээ. Үүнийг хүснэгтээр үзүүлбэл:

/Хүснэгт № 6/

/тэрбум төгрөг/

ҮЗҮҮЛЭЛТ		Тодотгол 1		Өөрчлөлт		Тодотгол 2	
		Нэгдсэн	Улсын	Нэгдсэн	Улсын	Нэгдсэн	Улсын
	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	7,954.4	5,920.1	1,740.0	1,829.5	9,694.4	7,749.7
А	УРСГАЛ ЗАРЛАГА	6,222.7	4,689.1	494.1	524.1	6,716.8	5,213.2
1.	Бараа, үйлчилгээний зардал	2,943.8	1,878.6	205.9	206.0	3,149.7	2,084.6
2.	Зээлийн үйлчилгээний төлбөр	947.8	870.7	100.1	116.5	1,047.9	987.2
3.	Татаас ба урсгал шилжүүлэг	2,331.1	1,939.8	188.1	201.6	2,519.2	2,141.4
Б	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	1,930.5	1,429.9	419.6	479.1	2,350.0	1,909.0
В	ЭРГЭЖ ТӨЛӨГДӨХ ЦЭВЭР ЗЭЭЛ	(198.8)	(198.9)	826.3	826.3	627.5	627.4

2.2.8 Хүснэгтээс үзвэл, батлагдсан төсвийн нийт өсөлтөд улсын төсвийн эргэж төлөгдөх цэвэр зээл, урсгал болон хөрөнгийн зардлын өсөлт голлон нөлөөлсөн байна.

2.2.9 Дээрх судалгааг 2016 оны төсөв батлах үеийн дүнгээр авсан бөгөөд төсвийн гүйцэтгэл гаргаж тайлагнах үед орон нутгийн төсвийн нийт зарлага 297.8 тэрбум төгрөгөөр нэмэгдэж батлагдсанаас шалтгаалан 2016 оны нэгдсэн төсвийн гүйцэтгэлийн тайланд нийт зарлагын батлагдсан төсвийг 9,992.2 тэрбум төгрөгөөр тусгасан байна.

2.2.10 Эргэж төлөгдөх цэвэр зээлийн өөрчлөлтийг авч үзвэл, эргэж төлөгдөх дотоод цэвэр зээлийг 834.3 тэрбум төгрөгөөр нэмэгдүүлж, эргэж төлөгдөх гадаад цэвэр зээлийг 8.0 тэрбум төгрөгөөр бууруулахаар тооцож, нийт дүнгээрээ 826.3 тэрбум төгрөгөөр өсөхөөр төлөвлөжээ.

2.2.11 Энэ нь төсвийн жилийн дундуур буюу 2016 оны 6 дугаар сарын 1-нээс Засгийн газрын тогтоолоор Нийгмийн даатгалын сан болон Нийгмийн халамжийн сангаас олгож буй тэтгэврийг 21.0 мянган төгрөгөөр нэмэгдүүлсэн, “Сайн” хөтөлбөрүүд хэрэгжүүлж Засгийн газрын бонд гарган санхүүжүүлсэн, Олон улсын арбитрын шүүхийн шийдвэрийн дагуу төлбөр төлсөн, УИХ-аас төсвийн жилийн дундуур хэрэгжиж эхлэх бөгөөд төсвөөс зардал нэмж шаардах хууль, тогтоомжийг баталсан, мөн өмнөх онуудад гэрээ байгуулж ажил нь хийгдсэн боловч төлбөрийг төсөвт тусган барагдуулах шаардлагатай төсөл, хөтөлбөрийн санхүүжилтийг олгосон, олгох шаардлага үүссэн зэрэгтэй холбоотой байна.

2.2.12 Сангийн яамны тооцоолсноор төсвийн тодотгол оруулах үеийн нөхцөл байдлыг өмнөх оны гүйцэтгэлтэй харьцуулбал урсгал зардал нийт 538.3 тэрбум төгрөгөөр буюу 17.0 хувиар өсөхөд бараа, үйлчилгээний зардал 278.0 тэрбум, зээлийн хүүгийн зардал 118.7 тэрбум, тэтгэвэр, тэтгэмжийн зардлын өсөлт болон урьд онд олгогдоогүй хүүхдийн мөнгөний санхүүжилтийг оны эхэнд олгосон зэргээс шалтгаалж урсгал шилжүүлгийн зардал 92.8 тэрбум төгрөгөөр тус тус нэмэгдсэн зэрэг хүчин зүйлс голлон нөлөөлсөн байна.

2.2.13 Бараа, үйлчилгээний бусад зардал өнгөрсөн оны мөн үеэс 50.0 хувиар нэмэгдэхэд Олон улсын арбитрын шүүхийн шийдвэрийн дагуу Канадын “Хан ресурс” компанид олгох нөхөн төлбөрийн зардалд 141.5 тэрбум, УИХ-ын ээлжит сонгууль зохион байгуулсантай холбоотой 14.5 тэрбум, Ази, Европын дээд хэмжээний 11 дүгээр уулзалт (АСЕМ)-ыг Улаанбаатар хотноо зохион байгуулсантай холбоотойгоор 18.3 тэрбум, мөн дулаан, эрчим хүчний үнэ тариф нэмэгдсэн, байр ашиглалтын тогтмол зардал урьд онтой харьцуулахад 18.1 тэрбум төгрөгөөр тус тус өссөн, гадаад зээлийн ашиглалтын зардал нэмэгдсэн зэргээс шалтгаалжээ.

2.2.14 Харин татаас, урсгал шилжүүлгийн зардал өссөн нь хүн амын насжилт, тэтгэвэр, тэтгэмжийн өсөлтийн улмаас Нийгмийн даатгалын сангаас олгох тэтгэвэр, тэтгэмжийн зардал өмнөх онтой харьцуулахад 54.7 тэрбум, халамжийн сангийн зардал 8.7 тэрбум төгрөгөөр тус тус нэмэгдсэн, “Хүүхдийн мөнгө” хөтөлбөрийн 2015 оны 12 дугаар сард олгогдох санхүүжилтийг 2016 оны 1 дүгээр сард санхүүжүүлж, гүйцэтгэл гаргасан нь голлон нөлөөлсөн байна.

2.2.15 Тайлант хугацаанд “Сайн” хөтөлбөрүүд хэрэгжүүлж, Засгийн газрын бонд гарган санхүүжүүлсэн арга хэмжээг төсөвт тусгахад төсвийн зарлагад нийт 553.8 тэрбум төгрөгөөр нөлөөлнө гэж тооцжээ.

2.2.16 Монгол Улсын нэгдсэн төсвийн нийт зарлага ба цэвэр зээлийн дүн 2016 онд 9,495.3 тэрбум төгрөгт хүрч, батлагдсан төсвийн 5.0 хувь буюу 496.8 тэрбум төгрөгөөр дутуу зарцуулагдсан байна.

2.2.17 Энэ нь батлагдсан төсөвтэй харьцуулахад урсгал зардлыг 4.4 хувь буюу 305.3 тэрбум, хөрөнгийн зардлыг 2.2 хувь буюу 52.0 тэрбум, эргэж төлөгдөх цэвэр зээлийг 21.1 хувь буюу 139.5 тэрбум төгрөгөөр тус тус дутуу санхүүжүүлсэнтэй холбоотой байна. Үүнийг хүснэгтээр үзүүлбэл:

/Хүснэгт № 7/

ҮЗҮҮЛЭЛТ		Нэгдсэн төсөв (тэрбум төгрөг)				ДНБ-д эзлэх хувь
		Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Хувь	
НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН		9,992.1	9,495.3	(496.8)	5.0	39.8
A.	УРСГАЛ ЗАРЛАГА	6,919.1	6,613.8	(305.3)	4.4	27.7
	Бараа, үйлчилгээний зардал	3,300.5	3,133.3	(167.2)	5.1	13.1
	Хүү	1,047.9	986.1	(61.8)	5.9	4.1
	Татаас ба урсгал шилжүүлэг	2,570.7	2,494.4	(76.3)	3.0	10.4
B.	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	2,412.2	2,360.2	(52.0)	2.2	9.9
B.	ЭРГЭЖ ТӨЛӨГДӨХ ЦЭВЭР ЗЭЭЛ	660.8	521.3	(139.5)	21.1	2.2

2.2.18 Урсгал зарлагын хэмнэлтэд бараа, үйлчилгээний зардал 167.2 тэрбум, хүүгийн зардал 61.8 тэрбум, татаасын зардал 27.6 тэрбум, урсгал шилжүүлэг 48.7 тэрбум төгрөгөөр тус тус дутуу зарцуулагдсан нь нөлөөлжээ.

2.2.19 Нэгдсэн төсвийн нийт зарлага ба цэвэр зээлийн 2016 оны гүйцэтгэлийг эдийн засгийн дэлгэрэнгүй ангиллаар гаргаж, Хавсралт №2-т үзүүлэв.

2.2.20 Монгол Улсын 2016 оны нэгдсэн төсвийн гүйцэтгэлийг төсвийн бүрэлдэхүүнээр өмнөх он болон батлагдсан төсөвтэй харьцуулан харуулбал:

/Хүснэгт № 8/

/тэрбум төгрөг/

Төсвийн бүрэлдэхүүн	2015 оны гүйцэтгэл	2016 оны батлагдсан төсөв	2016 оны гүйцэтгэл	Өмнөх оны гүйцэтгэлтэй харьцуулсан хувь	Батлагдсан төсөвтэй харьцуулсан хувь
Нэгдсэн төсөв	7,138.0	9,992.2	9,495.3	133.0	95.0
Улсын төсөв	4,996.9	7,749.7	7,394.2	148.0	95.4
Орон нутгийн төсөв	2,079.2	2,442.0	2,330.4	112.1	95.4
Хүний хөгжил сангийн төсөв	308.4	283.9	278.6	90.3	98.1
Нийгмийн даатгалын сангийн төсөв	1,541.5	1,764.8	1,720.3	111.6	97.5

2.2.21 Хүснэгтээс үзэхэд, улсын болон орон нутгийн төсөв, Нийгмийн даатгалын сангийн төсвийн зарлага өмнөх оны гүйцэтгэлээс 11.6-48.0 хувиар нэмэгдэж, төлөвлөсөн дүнгээс 2.5-4.6 хувиар дутуу зарцуулагдсан бол Хүний хөгжил сангийн төсвийн зарлага өмнөх оны гүйцэтгэл болон төлөвлөснөөс 1.9-9.7 хүртэл хувиар буурсан байна.

Засгийн газрын өрийн үйлчилгээний төлбөрийг бүрэн төлжээ

2.2.22 Тайлант онд Засгийн газрын өрийн үйлчилгээний төлбөрт нийт 1,047.9 тэрбум төгрөгийг төлөхөөр төлөвлөж, 986.1 тэрбум төгрөгийн гүйцэтгэл гарснаас гадаад өрийн хүүгийн төлбөрт 341.4 тэрбум, дотоод зээл, үнэт цаасны хүүгийн төлбөрт 644.7 тэрбум төгрөгийг тус тус төлжээ.

2.2.23 Гадаад зээлийн хүүгийн төлбөрт 74.4 тэрбум, гадаад үнэт цаасны хүүгийн төлбөрт 239.2 тэрбум, гэрээнд заасан бусад төлбөрийн үүрэг, хураамжид 27.8 тэрбум, нийт 341.4 тэрбум төгрөгийг гадаад өрийн үйлчилгээний төлбөрт төлсөн байна.

2.2.24 Тусгай зориулалтын болон улсын төсвийн мөнгөн хөрөнгийн дутагдлыг санхүүжүүлэх зорилгоор гаргасан үнэт цаасны хүүгийн зардал, хөнгөлөлтийн төлбөрт нийт 381.3 тэрбум төгрөгийг төлжээ. Тухайлбал,

- “Орон сууц” хөтөлбөр, банкны бүтцийн өөрчлөлт, жижиг, дунд үйлдвэр, ноос, ноолуурын салбарыг дэмжих зорилгоор гаргасан үнэт цаасны хүү нийт 0.6 тэрбум,
- “Сайн хөтөлбөр”-үүдийн хүүгийн зардал 4.8 тэрбум,
- Улсын төсвийн мөнгөн хөрөнгийн дутагдлыг санхүүжүүлэх зорилгоор гаргасан үнэт цаасны хүү 294.3 тэрбум, хөнгөлөлтийн төлбөр 81.6 тэрбум төгрөгийн гүйцэтгэлтэй байна.

2.2.25 Монголбанкнаас авсан дотоод зээлийн хүүд 2.3 тэрбум, векселийн хүүгийн төлбөрт 23.7 тэрбум, улсын төсвөөс эргэн төлөгдөх нөхцөлтэйгээр Хөгжлийн банкнаас санхүүжүүлсэн төслийн зээлийн хүүгийн төлбөрт 177.6 тэрбум төгрөгийг төлсөн байна.

2.2.26 Хүний хөгжил сангийн төсвийн мөнгөн хөрөнгийн дутагдлыг санхүүжүүлэх зорилгоор гаргасан үнэт цаасны хүү 40.1 тэрбум, хөнгөлөлтийн төлбөр 4.8 тэрбум, татварын урьдчилгаа төлбөрийн зээлийн хүүгийн зардал 14.9 тэрбум, нийт 59.8 тэрбум төгрөгийн гүйцэтгэлтэй байна.

Буцаан төвлөрүүлэхээр төлөвлөсөн зээлийн 40.1 хувь нь төлөгдөөгүй байна

2.2.27 Монгол Улсын 2016 оны нэгдсэн төсвийн эргэж төлөгдөх төлбөрийг хассан цэвэр зээлийн зардал 660.8 тэрбум төгрөгөөр төлөвлөгдсөнөөс 521.3 тэрбум төгрөгийн гүйцэтгэлтэй байна.

2.2.28 Монгол Улсын 2016 оны төсвийн тухай хуулиар 9 ТЕЗ-д нийт 596.8 тэрбум төгрөгийн эргэн төлөгдөх зээлийг олгож, өмнөх онуудад олгосон зээлээс 75.5 тэрбум төгрөг төвлөрүүлжээ.

Хүснэгтээр харуулбал:

/хүснэгт № 9/		/тэрбум төгрөг/		
Төсвийн ерөнхийлөн захирагч	Төсөл хөтөлбөрийн нэр	2016 оны		Зөрүү
		Төлөв	Гүйц	
Олгосон зээл, үүнээс		786.9	596.8	(190.1)
Боловсрол, соёл, шинжлэх ухаан, спортын сайд	Боловсролын зээлийн сан	90.8	31.0	(59.8)
Сангийн сайд	Олгох зээл /6 төсөл, арга хэмжээ/	572.7	467.4	(105.3)
Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайд	"Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих" сан	13.0		(13.0)
Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн сайд	Жижиг, дунд үйлдвэрийг хөгжүүлэх сан	55.7	55.7	0
	Зах зээл бэлчээрийн удирдлагын хөгжил төсөл	2.7	0.3	(2.4)
	Мал хамгаалах сан	1.9	1.5	(0.4)
Барилга, хот байгуулалтын сайд	Улаанбаатар хотын VII, XIV хорооллын орон сууцны хорооллын дэд бүтэц төсөл	0.6	0	(0.6)
Зам, тээврийн хөгжлийн сайд	Улс, хот хоорондын нийтийн тээврийн үйлчилгээнд дэмжлэг үзүүлэх төсөл	0.1	0	(0.1)
Эрчим хүчний сайд	Олгох зээл /6 төсөл, арга хэмжээ/	16.8	27.4	10.6
Орон нутгийн төсөв захирагчид	15 аймгийн төсвийн ерөнхийлөн захирагчид	32.6	13.5	(19.1)
Буцаан төлөгдсөн зээл, үүнээс		(126.1)	(75.5)	(50.6)
Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн сайд	ЖДҮДС: ЗГҮЦ, дамжуулан зээл	(52.0)	(51.9)	(0.1)
	Тариалан эрхлэлтийг дэмжих сан	(24.0)	-	(24.0)
Хууль зүй, дотоод хэргийн сайд	Банк, хадгаламж зээлийн хоршооны ажлын алба	(22.2)	-	(22.2)
Сангийн сайд	ААНБ болон улс, орон нутгийн төсөвт байгууллагууд	(27.9)	(23.6)	(4.3)
Эргэж төлөгдөх төлбөрийг хассан цэвэр зээлийн дүн		660.8	521.3	(139.5)

2.2.29 Тайлант онд Сангийн сайд, БСШУСС, ХХААХҮС болон орон нутгийн Төсвийн ерөнхийлөн захирагчид нийт 756.4 тэрбум төгрөгийн зээлийг дамжуулан зээлдүүлэхээр төлөвлөж, гүйцэтгэлээр 569.4 тэрбум төгрөг, харин ЭХС-ын төсөвт гадаад эх үүсвэрээс нийт 16.8 тэрбум төгрөгийн зээл олгохоор төлөвлөгдсөнөөс гүйцэтгэлээр 27.4 тэрбум төгрөгт хүрч, 10.6 тэрбум төгрөгөөр хэтэрчээ. Мөн ХНХС, БХБС, ЗТХС-ын төсвийн багцад нийт 13.7 тэрбум төгрөгийн зээл олгохоор төлөвлөсөн боловч гүйцэтгэл гараагүй байна.

2.2.30 Улсын төсөвт буцаан төвлөрүүлэх зээлийн төлөвлөгөөг 50.6 тэрбум төгрөгөөр буюу 40.1 хувиар дутуу биелүүлсэн байна. Тухайлбал,

Хууль зүй, дотоод хэргийн сайд-ТЕЗ:

Хадгаламж зээлийн хоршоодод мөнгөө хадгалуулсан иргэдэд учирсан хохиролд төсвөөс олгосон зээлийн 22.2 тэрбум төгрөгийн авлага хуульд орсон өөрчлөлтийн улмаас эргэн төлөгдөх нь эрсдэлтэй байна.

Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн сайд-ТЕЗ:

ТЭДС-гаас Монгол Улсыг хөгжүүлэх санд төлөх улаан буудайн өрийн үлдэгдэл 24.0 тэрбум төгрөг,

Сангийн сайд-ТЕЗ:

ААНБ болон улс орон нутгийн төсөвт байгууллагад өмнөх онуудад дамжуулан зээлдүүлсэн зээлээс 4.3 тэрбум төгрөгийг тус тус төвлөрүүлээгүй байна.

2.3 Нэгдсэн төсвийн тэнцэл

2.3.1 Монгол Улсын 2016 оны нэгдсэн төсвийн тэнцвэржүүлсэн тэнцлийг 4,563.0 тэрбум төгрөгийн алдагдалтай байхаар төлөвлөснөөс гүйцэтгэлээр 3,660.3 тэрбум төгрөгийн алдагдалтай буюу 902.7 тэрбум төгрөгөөр буурсан байна. Үүнийг төсвийн бүтцээр харуулбал:

/хүснэгт №10/

/тэрбум төгрөг/

Үзүүлэлт	2015 оны гүйцэтгэл	2016 оны		
		Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү
Нэгдсэн төсөв	(1,156.9)	(4,563.0)	(3,660.3)	902.7
Улсын төсөв	(1,165.2)	(4,183.1)	(3,499.8)	683.3
Орон нутгийн төсөв	(45.4)	(253.4)	(160.6)	92.8
Хүний хөгжил сангийн төсөв	114.7	(114.1)	(89.5)	24.6
Нийгмийн даатгалын сангийн төсөв	(61.0)	(12.4)	89.6	102.0

2.3.2 Хүснэгтээс үзвэл, тайлант онд Нийгмийн даатгалын сангийн төсөв 12.4 тэрбум төгрөгийн алдагдалтай төлөвлөгдсөнөөс 89.6 тэрбум төгрөгийн ашигтай гарсан, улсын болон орон нутгийн, Хүний хөгжил сангийн төсвийн алдагдал төлөвлөсөн хэмжээнээс 24.6-683.3 тэрбум төгрөгөөр буурсан нь нэгдсэн төсвийн нийт алдагдал 902.7 тэрбум төгрөгөөр буурахад нөлөөлжээ.

2.3.3 Нэгдсэн төсвийн алдагдлыг нөхөх зорилгоор тайлант онд 5,058.2 тэрбум төгрөгийн Засгийн газрын үнэт цаас арилжаалж, 1,550.0 тэрбум төгрөгийн зээл авч, 252.8 тэрбум төгрөгийн улсын төсвөөс эргэн төлөгдөх нөхцөлтэй хөрөнгө оруулалтын гүйцэтгэлийг Хөгжлийн банкнаас санхүүжүүлсэн байна.

2.3.4 Дээрх эх үүсвэрүүдээс ЗГҮЦ-ны эргэн төлөлтөд 1,725.5 тэрбум, Хөгжлийн банкны дүрмийн санг нэмэгдүүлэхэд 1,000.0 тэрбум, зээлийн эргэн төлөлтөд 335.6 тэрбум төгрөгийг тус тус зарцуулж, татварын урьдчилгаа төлбөрөөс 27.3 тэрбум төгрөгийг суутган тооцож, үлдэх 3,660.3 тэрбум төгрөгөөр 2016 оны нэгдсэн төсвийн алдагдлыг санхүүжүүлснээр харилцах болон хадгаламжийн дансдын үлдэгдэл 112.3 тэрбум төгрөгөөр өссөн байна.

2.4 Монгол Улсын Засгийн газрын өр

2.4.1 УИХ-аас 2015 оны 2 дугаар сарын 18-ны өдөр баталсан Өрийн удирдлагын тухай хуулиар “Улсын өр”-ийн тодорхойлолтыг “Засгийн газрын өр”¹¹ гэж өөрчилсөн ба өрийн /нэрлэсэн үнээрх/ нийт үлдэгдлийг сүүлийн 2 жилийн байдлаар харуулбал:

/хүснэгт №11/

/тэрбум төгрөг/

Үзүүлэлт	2015 он	2016 он	Өөрчлөлт
Гадаад зээлийн үлдэгдэл	4,456.8	6,983.3	2,526.5
Гадаад үнэт цаасны үлдэгдэл	3,315.8	5,380.5	2,064.7
Өрийн баталгааны үлдэгдэл	2,743.5	3,451.5	708.0
Гадаад өр	10,516.1	15,815.3	5,299.2
Дотоод үнэт цаасны үлдэгдэл	3,333.2	5,488.8	2,155.6
Татварын урьдчилгаа төлбөр /"Оюутолгой" ХХК/	41.4	-	(41.4)
Төсвөөс эргэн төлөх концессын үлдэгдэл	261.0	668.9	407.9
Векселийн өр	164.3	307.2	142.9
Дотоод өр	3,799.9	6,464.9	2,665.0
Өрийн нийт дүн	14,316.0	22,280.2	7,964.2

2.4.2 Хүснэгтээс үзвэл, Засгийн газрын 2016 оны өрийн үлдэгдлийн 71.0 хувийг гадаад, 29.0 хувийг дотоод өр эзэлж байна.

2.4.3 Засгийн газрын өрийн хэмжээ өмнөх оноос 7,964.2 тэрбум төгрөгөөр өссөнөөс өрийн үлдэгдэлд гадаад зээл 31.3, дотоод үнэт цаас 24.6, гадаад үнэт цаас 24.1, Засгийн газрын өрийн баталгаа 15.5, бусад өр 4.5 хувийг тус тус эзэлж байна.

¹¹ орон нутгийн өмчит болон орон нутгийн өмч давамгайлсан, төрийн өмчит болон төрийн өмч давамгайлсан аж ахуйн нэгжүүдийн өрийг оруулахгүй болсон

Гадаад өрийн өсөлтийн 56.1 хувь нь ханшийн зөрүүнээс шалтгаалжээ

2.4.4 Засгийн газрын гадаад өрийн бүтэц нь гадаад зээл болон үнэт цаас, өрийн баталгаанаас бүрдэж байна.

/хүснэгт №12/				/тэрбум төгрөг/			
Гадаад өрийн ангилал	Эхний үлдэгдэл	Ашиглалт	Эргэн төлөлт	Ханшийн өөрчлөлт	Бусад	Эцсийн үлдэгдэл	Хувь
Гадаад зээл	4,456.8	1,350.1	135.6	1,223.9	88.1	6,983.3	44.2
Гадаад үнэт цаас	3,315.8	1,021.2	-	1,043.5		5,380.5	34.0
Өрийн баталгаа	2,743.5	188.7	189.1	708.4		3,451.5	21.8
Нийт дүн	10,516.1	2,560.0	324.7	2,975.8	88.1	15,815.3	100.0

2.4.5 Засгийн газрын гадаад валютаар илэрхийлэгдэж байгаа өрийн багцад ам.доллар 31.7 хувийг, зээлжих тусгай эрх 35.7 хувийг, иен 22.5 хувийг, евро 6.1 хувийг, бусад валют 4.0 хувийг тус тус эзэлж байгаа бөгөөд тайлант оны эцсийн үлдэгдлийн 1 ам.долларын ханшийг 2,489.53 төгрөгөөр тооцон илэрхийлсэн байна.

2.4.6 Гадаад зээл Засгийн газрын гадаад зээлийн үлдэгдэл өмнөх онд 4,456.8 тэрбум төгрөг байснаас тайлант онд 6,983.3 тэрбум төгрөгт хүрч, 2,526.5 тэрбум төгрөгөөр өссөн байна.

/хүснэгт №13/				/тэрбум төгрөг/			
Гадаад зээлийн ангилал	Эхний үлдэгдэл	Ашиглалт	Эргэн төлөлт	Ханшийн өөрчлөлт	Бусад	Эцсийн үлдэгдэл	Хувь
Хөтөлбөрийн зээл	199.6	587.5	-	183.8		970.9	13.9
Төслийн зээл	4,257.2	762.6	135.6	1,040.1	88.1	6,012.4	86.1
Нийт гадаад зээл	4,456.8	1,350.1	135.6	1,223.9	88.1	6,983.3	100.0

2.4.7 Монгол Улсын Засгийн газар гадаад орон, олон улсын банк, санхүүгийн байгууллагаас 2016 онд 632.6 сая ам.доллар буюу 1,350.1 тэрбум төгрөгийн гадаад зээлийг авч ашигласан нь өмнөх оноос 845.0 тэрбум төгрөгөөр илүү байна.

2.4.8 Гадаад зээлийн үйлчилгээний төлбөрт тайлант онд 210.0 тэрбум, үүнээс үндсэн төлбөрт 135.6 тэрбум, хүүгийн төлбөрт 74.4 тэрбум төгрөгийг төлж, гадаад зээлийн үлдэгдэл 2016 оны жилийн эцсийн байдлаар 2,805.1 сая ам.доллар буюу 6,983.3¹² тэрбум төгрөг байна.

2.4.9 Тайлант онд авч ашигласан нийт зээлийн 46.7 хувь Сангийн сайдад, 36.9 хувь Зам, тээврийн хөгжлийн сайдад ногдож байна.

2.4.10 Гадаад үнэт цаас Засгийн газрын гадаад үнэт цаас нь нийт өрийн багцын 24.1 хувийг эзэлж байгаа бөгөөд 2016 онд олон улсын зах зээлд 500.0 сая ам.доллар буюу 1,021.2 тэрбум төгрөгийн Мазаалай¹³ бондыг арилжаалж, Чингис¹⁴ болон Дим сам¹⁵ бондыг оролцуулан нийт гадаад үнэт цаасны 2016 оны 12 дугаар сарын 31-нээрх нэрлэсэн үлдэгдэл 2,161.2 сая ам.доллар буюу 5,380.5 тэрбум төгрөг байна. Үнэт цаасны төрлөөр хүснэгтээр үзүүлбэл:

/хүснэгт №14/				/тэрбум төгрөг/					
Гадаад үнэт цаасны нэр	Гаргасан огноо	Хүүгийн түвшин хувиар	Зээлийн дүн сая/ам.дол	Эхний үлдэгдэл	Ашиглалт	Үндсэн төлбөр	Ханшийн өөрчлөлт	Эцсийн үлдэгдэл	Хүүгийн төлбөр
Чингис бонд - 12-0.5	12/5/2012	4.125	500.0	998.0	0.0	0.0	246.8	1,244.8	41.1
Чингис бонд - 12-1.0	12/5/2012	5.125	1,000.0	1,996.0	0.0	0.0	493.5	2,489.5	114.2
Дим сам бонд	6/30/2015	5.960	161.2	321.8	0.0	0.0	79.6	401.4	21.7

¹² Монголбанкнаас зарласан 2016 оны 12 дугаар сарын 30-ны өдрийн 1 ам.долларын ханш 2489.53 төгрөг болно.

¹³ 2016 оны 4 дүгээр сард 1,021.2 тэрбум төгрөг (500.0 сая ам.доллар)-ийн, 2021 онд төлөгдөх хуваарьтай, 10.875 хувийн хүүтэй.

¹⁴ 2012 оны 12 дугаар сард 10 жилийн хугацаатай 1.0 тэрбум ам.долларын бондыг 5.125 хувийн хүүтэйгээр, 5 жилийн хугацаатай 500.0 сая ам.долларын бондыг 4.125 хувийн хүүтэйгээр, нийт 1.5 тэрбум ам.долларын Чингис бондыг олон улсын зах зээлд арилжаалсан.

¹⁵ Засгийн газрын 2015 оны 249 дүгээр тогтоолоор олон улсын зах зээлд 3.5 жилийн хугацаатай, 350 сая хүртэл ам.доллартай тэнцэх хэмжээний юаниар илэрхийлсэн ЗГҮЦ гаргахаар шийдвэрлэсний дагуу арилжсан 3 жилийн хугацаатай 1.0 тэрбум юаньтай тэнцэх үнэт цаас

Мазаалай бонд -0.5	4/06/2016	10.875	500.0	0.0	1,021.2	0.0	223.6	1,244.8	62.2
НИЙТ ДҮН			2,161.2	3,315.8	1,021.2	0.0	1,043.5	5,380.5	239.2

2.4.11 Гадаад бондын хүүгийн төлбөрт тайлант жилд 108.8 сая ам.доллар буюу 239.2 тэрбум төгрөгийг төлсөн байна.

2.4.12 Өрийн баталгаа Засгийн газрын өрийн баталгаа тайлант оны эцэст 3,451.5 тэрбум төгрөгийн үлдэгдэл байгааг хүснэгтээр үзүүлбэл:

/хүснэгт №15/

/тэрбум төгрөг/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Ашиглалт	Эргэн төлөлт	Ханшийн өөрчлөлт	Эцсийн үлдэгдэл	Эзлэх хувь
Хөгжлийн банк	2,553.1	176.9	164.1	663.9	3,229.8	93.6
“МИАТ” ТӨХК	190.4		25.0	43.2	208.6	6.0
“Эрдэнэс Монгол” ХХК	0.0	11.8		1.3	13.1	0.4
Өрийн баталгааны дүн	2,743.5	188.7	189.1	708.4	3,451.5	100.0

2.4.13 Хөгжлийн банкны өрийн баталгааг авч үзвэл,

- Евро бонд 580.0 сая ам.доллар буюу 1,443.9 тэрбум,
- Самурай бонд 30.0 тэрбум иен буюу 635.7 тэрбум,
- БНХАУ-ын Хөгжлийн банкны зээл 162.0 сая ам.доллар буюу 403.3 тэрбум,
- Кредит Свисс банкны зээл 300.0 сая ам.доллар буюу 746.9 тэрбум төгрөг байна.

2.4.14 “Боинг” нисэх онгоц худалдан авсан “МИАТ” ТӨХК-ийн зээлд гаргасан өрийн баталгаанаас 2016 оны эргэн төлөлт 25.0 тэрбум төгрөгийг хорогдуулж, ханшийн өөрчлөлт 43.2 тэрбум төгрөгөөр нэмэгдүүлэн 83.8 сая ам.доллар буюу 208.6 тэрбум төгрөгийн үлдэгдэлтэй байна.

2.4.15 “Эрдэнэс Монгол” ХХК-ийн үйл ажиллагааны эрсдэлийн болон санхүүгийн нэгдсэн удирдлагын тогтолцоог бэхжүүлэх зорилгоор хэрэгжүүлэх нийт 42.0 сая ам.долларын санхүүжилт бүхий төслийн 85.0 хувь буюу Азийн хөгжлийн банкнаас авах 35.0 сая ам.долларын зээлд Засгийн газрын өрийн баталгаа гаргахаар шийдвэрлэснээс тайлант оны ашиглалт 5.2 сая ам.доллар буюу 13.1 тэрбум төгрөгийн үлдэгдэлтэй байна.

Засгийн газрын дотоод өрийн 84.4 хувийг ЗГҮЦ-ны өглөг эзэлж байна

2.4.16 Дотоод үнэт цаас Оны эхэнд 3,333.2 тэрбум төгрөгийн үлдэгдэлтэй байснаас 2016 онд нийт 3,902.5 тэрбум төгрөгийн нэрлэсэн үнэ бүхий дотоод үнэт цаасыг гаргаж арилжаалсан ба тайлант онд 1,811.9 тэрбум төгрөгийн үнэт цаасыг буцаан төлж, гадаад валютаар дотоодод гаргасан үнэт цаасны ханшийн зөрүү 65.0 тэрбум төгрөгөөр нэмэгдүүлэн тайлант оны эцэст 5,488.8 тэрбум төгрөгийн үлдэгдэлтэй байна.

2.4.17 Төсвөөс эргэн төлөх концесс Өрийн удирдлагын тухай хуулийн 40 дүгээр зүйлийн 40.7-д¹⁶ заасны дагуу төлөх үлдэгдэл 2016 оны эхэнд 261.0 тэрбум төгрөг байснаас тайлант жилийн ашиглалт, тооцоо нийлсэн бүртгэлээр 407.9 тэрбум төгрөгөөр нэмэгдэж, 668.9 тэрбум төгрөгийн үлдэгдэлтэй байна. Үүнээс, улсын төсвөөс эргэн төлөгдөх нөхцөлтэй (барих-шилжүүлэх төрөл) нийт 34 концессын гэрээ байгуулж, эдгээр гэрээний хүрээнд гарсан ашиглалт, эргэн төлөлтийг оруулж тооцсоноор 623.1 тэрбум төгрөгийн үлдэгдэлтэй байгаа бол орон нутгийн төсвөөс эргэн төлөх нөхцөлтэй нийт 31 гэрээний дагуу төлөх төлбөрийн үүрэг 45.8 тэрбум төгрөг байна.

2.4.18 Вексель Оны эхний үлдэгдэл 164.3 тэрбум төгрөг байснаас хөрөнгө оруулалтын төсөл арга хэмжээний төлбөрт Засгийн газрын 2015 оны 282 дугаар тогтоолын дагуу 1.0 тэрбум, 2016 оны 72 дугаар тогтоолын дагуу нийт 142.9 тэрбум, концессын гэрээний төлбөрт 335.0 тэрбум, татварын урьдчилгаа төлбөрт 54.0 тэрбум, нийт 532.9 тэрбум төгрөгийн векселийг бичсэн байна. Векселийн үндсэн төлбөрт 390.0 тэрбум төгрөгийг төлж, 2016 оны жилийн эцсийн байдлаар үлдэгдэл 307.2 тэрбум төгрөг байна. Векселийн хүүгийн төлбөрт 23.7 тэрбум төгрөгийг төлжээ.

¹⁶ “Улсын болон орон нутгийн төсвөөс эргэн төлөгдөх нөхцөлтэй концессын гэрээг хүчин төгөлдөр болсон өдрөөр өрийн мэдээллийн нэгдсэн санд оруулж, концессын гэрээний дагуу улирал бүр гарсан ашиглалтыг үндэслэж Засгийн газрын өрд бүртгэнэ”

БҮЛЭГ 3. МОНГОЛ УЛСЫН 2016 ОНЫ ТӨСӨВ

3.1 Улсын төсвийн орлого

/хүснэгт №16/

3.1.1 2016 онд улсын төсвийн нийт орлого ба тусламжийн дүнг 3,566.6 тэрбум төгрөгөөр төлөвлөснөөс гүйцэтгэлээр 3,894.4 тэрбум төгрөгийн орлого төвлөрүүлж, төлөвлөгөө 109.2 хувь буюу 327.8 тэрбум төгрөгөөр давж биелсэн, өмнөх оны гүйцэтгэлээс 60.4 тэрбум төгрөгөөр буюу 1.6 хувиар өссөн нь импортын хэмжээ буурсан боловч ДНБ болон экспорт өссөнтэй холбоотой байна. Орлогын гүйцэтгэлийг нэр төрлөөр харуулбал:

Үзүүлэлт	2013 гүйц	2014 гүйц	2015 гүйц	2016 гүйц
ДНБ-ийн бодит өсөлт /хувь/	11.6	7.4	2.3	3.2
Экспорт /сая ам.доллар/	4,272.7	5,614.3	4,669.5	4,916.3
Импорт /сая ам.доллар/	6,354.7	5,253.7	3,797.5	3,358.1
Ам.долларын дундаж ханш /төгрөг/	1,523.9	1,818.1	1,970.7	2,145.5

/хүснэгт №17/

/тэрбум төгрөг/

Улсын төсвийн орлогын ангилал, зүйл	2015 оны гүйцэтгэл	2016 он			
		Төлөв	Гүйц	Зөрүү	Хувь
НИЙТ ОРЛОГО БА ТУСЛАМЖИЙН ДҮН	3,834.0	3,566.6	3,894.4	327.8	109.2
ТОГТВОРЖУУЛАЛТЫН САН	2.3	0.0	0.0	0.0	0.0
НИЙТ ТЭНЦВЭРЖҮҮЛСЭН ОРЛОГО БА ТУСЛАМЖИЙН ДҮН	3,831.7	3,566.6	3,894.4	327.8	109.2
A. УРСГАЛ ОРЛОГО	3.612.5	3,566.6	3,894.4	327.8	109.2
I. ТАТВАРЫН ОРЛОГО	2,943.4	2,533.8	2,854.1	320.3	112.6
Аж ахуйн нэгжийн орлогын албан татвар	688.5	433.9	520.0	86.1	119.8
Нэмэгдсэн өртгийн албан татвар	1,049.6	1,081.3	1,140.7	59.4	105.5
Онцгой албан татвар	592.3	531.8	630.1	98.3	118.5
Тусгай зориулалтын орлого	11.8	8.6	10.8	2.2	125.6
Гаалийн албан татвар	320.6	302.2	328.5	26.3	108.7
Бусад татвар	280.6	176.0	224.0	48.0	127.3
II. ТАТВАРЫН БУС ОРЛОГО	888.3	1,032.8	1,040.4	7.6	100.7

3.1.2 Тайлант онд татварын орлого төлөвлөсөн хэмжээнээс 320.3 тэрбум төгрөгөөр давж биелсэн бол өмнөх оны гүйцэтгэлээс 89.3 тэрбум төгрөгөөр буурчээ.

3.1.3 Татварын орлогыг бүтцээр нь авч үзвэл, Аж ахуйн нэгжийн орлогын албан татвар 18.2 хувь, Нэмэгдсэн өртгийн албан татвар 40.0 хувь, Онцгой албан татвар 22.1 хувь, Тусгай зориулалтын орлого 0.4 хувь, Гаалийн албан татвар 11.5 хувь, бусад татвар 7.8 хувийг тус тус бүрдүүлсэн байна.

3.1.4 Тайлант онд улсын төсөвт “Оюутолгой” ХХК нийт 276.9 тэрбум төгрөгийн татвар төлсөн бол “Эрдэнэт үйлдвэр” ХХК нийт 87.8 тэрбум төгрөгийн татварын орлогыг төвлөрүүлсэн байна.

3.1.5 Сүүлийн 5 жилийн судалгаагаар аж ахуйн нэгжийн орлогын албан татвар төлөгчдийн тоо жилд дунджаар 9,155 татвар төлөгчөөр буюу 9.7 хувиар өссөн ба 2015 онд татвар төлөгчдөөс хүлээн авсан ААНОАТ-ын тайлангийн 61.1 хувь нь “Х” болон алдагдалтай тайлан ирүүлж байсан бол 2016 оны жилийн эцсийн байдлаар 68.0 хувь болж 6.9 пунктээр өссөн байна. Хүснэгтээр харуулбал:

/хүснэгт №18/

Он	Тайлан ирүүлбэл зохих татвар төлөгчийн тоо	Тайлан ирүүлсэн татвар төлөгчийн тоо	Үүнээс: “Х” тайлан	Алдаг- далтай тайлан	Ногдолтой тайлан	Тайлан ирүүлээгүй татвар төлөгчийн тоо	Ирц хувь
2012	82,479	69,453	26,184	10,828	32,441	13,026	84.2
2013	92,791	73,700	27,386	12,369	33,945	19,091	79.4
2014	105,085	79,330	29,931	19,115	30,284	25,755	75.5

2015	112,760	83,548	33,588	17,458	32,502	29,212	74.1
2016	119,099	81,052	38,021	17,054	25,977	38,047	68.0

*Эх сурвалж: Сангийн яамны мэдээлэлд суурилав.

3.1.6 2016 онд татварын байгууллагад тайлан ирүүлсэн 81.0 мянган аж ахуйн нэгж, байгууллагаас 55.1 мянга нь үйл ажиллагаа явуулаагүй болон алдагдалтай ажилласан нь ААНОАТ-ын ногдол өмнөх оноос буурахад тодорхой хэмжээгээр нөлөөлсөн байна.

3.1.7 Нэмэгдсэн өртгийн албан татвараар улсын төсөвт 1,081.3 тэрбум төгрөг төвлөрүүлэхээс 1,140.7 тэрбум төгрөг төвлөрүүлж, төлөвлөгөө 5.5 хувиар буюу 59.4 тэрбум төгрөгөөр давж биелжээ. НӨАТ-ын төлөвлөгөө давж биелсэн нь НӨАТ-ын тухай хуульд нэмэлт өөрчлөлт оруулснаар татварын ногдуулалт нэмэгдсэнтэй холбоотой байна.

3.1.8 НӨАТ-ын тайлангийн сүүлийн 5 жилийн судалгаагаар тайлан ирүүлбэл зохих татвар төлөгчдийн тоо өмнөх оноос жилд дунджаар 12.0 хувиар буурч байсан бол 2016 онд өмнөх оны түвшинд байна. Тайлант онд 32.8 мянган аж ахуйн нэгж байгууллагын 81.5 хувь нь тайлан ирүүлсэн бөгөөд НӨАТ ногдох борлуулалтын орлого 18.2 их наяд төгрөгт хүрч, өмнөх оны мөн үеэс 1.1 хувиар өсч, НӨАТ-тай худалдан авалт 15.3 их наяд төгрөг болсон нь өмнөх оны мөн үеэс 2.5 хувиар буурсан байна.

3.1.9 Онцгой албан татварын орлогоор улсын төсөвт 531.8 тэрбум төгрөг оруулахаас гүйцэтгэлээр 630.1 тэрбум төгрөг орж, төлөвлөгөө 18.5 хувиар буюу 98.3 тэрбум төгрөгөөр давж биелсэн ба өмнөх оны мөн үеийн гүйцэтгэлээс 6.4 хувиар 37.8 тэрбум төгрөгөөр өссөн байна.

/хүснэгт №19/

/тэрбум төгрөг/

Улсын төсөвт төвлөрүүлсэн ОАТ	гүйцэтгэл				2016	
	2012	2013	2014	2015	төл	гүйц
Дотоодын архи, дарс	92.6	148.2	160.3	129.0	114.2	138.4
Дотоодын пиво	17.6	21.8	27.9	23.7	19.1	22.4
Дотоодын тамхи	15.7	39.6	45.7	31.8	32.5	32.8
Нийт орлого	125.9	209.6	233.9	184.5	165.8	193.6

3.1.10 2016 онд дотоодын барааны онцгой албан татварын орлогоор 193.6 тэрбум төгрөг төсөвт төвлөрсөн нь өмнөх оны гүйцэтгэлээс 9.1 тэрбум төгрөгөөр илүү байна.

/хүснэгт №20/

/тэрбум төгрөг/

3.1.11 Импортын барааны онцгой албан татварын орлогоор нийт 366.0 тэрбум төгрөгийн орлого оруулахаас гүйцэтгэлээр 436.5 тэрбум төгрөгт хүрч, төлөвлөгөө 19.3 хувиар буюу 70.5 тэрбум төгрөгөөр давж биелсэн байна.

Улсын төсвийн импортын ОАТ	2015	2016	
	гүйц	төл	гүйц
Автобензин, дизелийн түлш	279.1	271.0	320.7
Суудлын автомашин	43.5	24.0	27.1
Импортын архи, тамхи	80.5	67.6	83.8
Импортын пиво	4.7	3.4	4.9
Нийт орлого	407.8	366.0	436.5

3.1.12 Автобензин, дизелийн түлшний онцгой албан татвар Өмнөх онд 279.1 тэрбум төгрөг төвлөрч байсан бол тайлант онд 271.0 тэрбум төгрөг төвлөрөхөөр тооцож, гүйцэтгэлээр 320.7 тэрбум төгрөг төвлөрсөн нь автобензин, дизелийн түлшний онцгой албан татварын хэмжээ нэмэгдсэнтэй¹⁷ холбоотой байна.

¹⁷ Засгийн газрын 2014 оны 24 дүгээр тогтоолоор автобензин, дизелийн түлшний тн тутамд 30.0 мянган төгрөгийн татвар ногдуулахаар байсан бол 2015 оны 18 дугаар тогтоолоор автобензинд 270.0-400.0 мянга, дизелийн түлшинд 390.0-520.0 мянган төгрөгийн татвар ногдуулах болсон байна.

3.1.13 Гаалийн албан татвар 2016 онд гаалийн албан татвараар 302.2 тэрбум төгрөгийн орлого төвлөрүүлэхээс гүйцэтгэлээр 328.5 тэрбум төгрөгт хүрч, төлөвлөгөө 8.7 хувь буюу 26.3 тэрбум, өмнөх оны мөн үеэс 2.4 хувь буюу 7.8 тэрбум төгрөгөөр тус тус давж биелсэн нь төгрөгөөр илэрхийлсэн татвартай импортын хэмжээ төлөвлөсөн хэмжээнээс 436.0 тэрбум төгрөгөөр өссөнтэй холбоотой байна.

3.1.14 Ашигт малтмалын нөөц ашигласны төлбөр Тайлант онд нийт 89.4 тэрбум төгрөгийн орлого төвлөрүүлэхээс гүйцэтгэлээр 101.0 тэрбум төгрөгийн орлого төвлөрч, төлөвлөгөө 11.6 тэрбум төгрөгөөр буюу 13.0 хувиар давж биелсэн байна. АМНАТ-ийн орлогын гүйцэтгэлийг өмнөх оны мөн үетэй харьцуулахад 79.6 тэрбум төгрөгөөр буурсан байна. Энэ нь тайлант онд төлөвлөгдсөн АМНАТ-ийн орлогоос 38.5 тэрбум төгрөгийн орлогыг 2015 оны 12 дугаар сард урьдчилан төвлөрүүлсэн, мөн экспортын гол нэрийн эрдэс бүтээгдэхүүний үнийн бууралттай холбоотой байна.

3.1.15 Тусгай зориулалтын орлого 2016 онд автобензин, дизелийн түлшний албан татварын 8.6 тэрбум төгрөгийн орлого төвлөрүүлэхээр тооцоолсноос гүйцэтгэлээр 10.8 тэрбум төгрөгийг төсөвт төвлөрүүлж, гүйцэтгэл нь 25.6 хувиар буюу 2.2 тэрбум төгрөгөөр давсан үзүүлэлттэй байна. Тусгай зориулалтын орлого өмнөх оны мөн үеэс 8.5 хувиар буюу 1.0 тэрбум төгрөгөөр буурсан байна.

3.1.16 Бусад татвар (төлбөр, хураамж) Уг татвараар нийт 176.0 тэрбум төгрөгийн орлого орохоос гүйцэтгэлээр 224.0 тэрбум төгрөгийн орлого олж, төлөвлөснөөс 27.3 хувь буюу 48.0 тэрбум төгрөгийн орлого илүү төвлөрсөн байна. Бусад татварын гүйцэтгэл өмнөх оны мөн үеийн гүйцэтгэлээс 56.6 тэрбум төгрөг буюу 20.2 хувиар буурсан үзүүлэлттэй байна.

3.1.17 Татварын бус орлого нийт дүнгээрээ төлөвлөсөн хэмжээнээс 7.6 тэрбум төгрөгөөр давж биелсэн боловч зарим нэр төрлийн орлого тасарчээ. Тухайлбал,

- Ногдол ашгийн орлого Тус орлогоор 8.4 тэрбум төгрөг төвлөрүүлэхээс гүйцэтгэлээр 3.3 тэрбум төгрөг төвлөрч төлөвлөснөөс 5.1 тэрбум төгрөгөөр дутуу байгаа нь төрийн өмчит аж ахуйн нэгжүүд 2015 оны санхүүгийн тайлангаарх ашгаас тооцсон хувьцааны ногдол ашгийг бүрэн төвлөрүүлээгүй, зарим аж ахуйн нэгж байгууллагын санхүүгийн үр дүн, ашиг төлөвлөсөн хэмжээнд хүрээгүй зэргээс шалтгаалсан байна.

3.1.18 Ногдол ашгийн орлогыг дутуу төвлөрүүлсэн буюу төвлөрүүлээгүй төрийн өмчит аж ахуйн нэгж байгууллагуудыг хүснэгтээр харуулбал:

/Хүснэгт №21/		2015 оны аудит хийгдсэн санхүүгийн тайлан тэнцлийн дүн			/тэрбум төгрөг/	
д/д	Аж ахуйн нэгж байгууллагын нэрс	Цэвэр ашиг	Тооцох хувь	Тооцсон ногдол ашиг	Гүйцэтгэлээрх ногдол ашиг	Зөрүү
1	Эрдэнэт Булганы ЦТС	2.8	20	0.6	0.1	(0.5)
2	МИАТ	5.3	30	1.6	0.5	(1.1)
3	Шивээ -Овоо	0.6	30	0.2	-	(0.2)
4	ИНЕГ	4.9	30	1.5	-	(1.5)
Нийт дүн		13.6		3.9	0.6	(3.3)

3.1.19 Мөн Хүний хөгжил санд ногдол ашиг төвлөрүүлэх төлөвлөгөөтэй “Эрдэнэт үйлдвэр” ХХК 3.0 тэрбум төгрөгийг төвлөрүүлээгүй байна.

3.1.20 Иймд 2016 оны дээрх аж ахуйн нэгж байгууллагуудын төвлөрүүлбэл зохих ногдол ашгийг төлбөрийн актаар улсын төсөвт татан төвлөрүүлэх нь зүйтэй гэж үзлээ.

3.1.21 Төсөвт байгууллагын өөрийн орлогоор 238.2 тэрбум төгрөг төвлөрүүлэхээр тооцож, гүйцэтгэлээр 230.2 тэрбум төгрөгийн орлого төвлөрүүлж, төлөвлөснөөс 3.4 хувиар буюу 8.0 тэрбум төгрөгөөр дутуу төвлөрсөн байна.

3.1.22 Улсын төсөвт төвлөрүүлэх орлогын төлөвлөгөө тасарсан шалтгааныг байгууллага тус бүрээр тодруулбал:

- Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ерөнхий газар: Гурван шатны шүүхээр “Шийдвэр гүйцэтгэгчид урамшуулал олгох журам”-ын 2 дугаар хавсралтыг түр түдгэлзүүлсэн,
- Цагдаагийн ерөнхий газар: Жолооны үнэмлэхний бэлдэц 2016 оны 5,6 дугаар саруудад тасарснаас хэвлэлт зогсож, оны сүүлийн саруудад жолооны үнэмлэх хэвлэгдсэн,
- Барилга, хот байгуулалтын яамны харьяа Барилгын хөгжлийн төвийн техник хяналтын орлого 0.4 тэрбум төгрөгөөр тасарсан нь эдийн засгийн хүндрэлийн улмаас хөрөнгө оруулалтын ажил буурсан, улсын төсвийн хөрөнгө оруулалтаар хийгдэж буй төсөл арга хэмжээ багасаж, царцсан барилга байгууламжийн тоо нэмэгдсэн зэрэг нь тус тус нөлөөлсөн байна.

Татварын зарлага

3.1.23 Тайлант онд хууль тогтоомжийн дагуу олгосон татварын хөнгөлөлт, чөлөөлөлт 908.3 тэрбум төгрөг буюу нийт тэнцвэржүүлсэн орлогын 15.6 хувьд хүрсэн байна. Тайлант оны татварын хөнгөлөлт чөлөөлөлт нь өмнөх оны мөн үеэс 251.5 тэрбум төгрөг буюу 38.3 хувиар өссөн үзүүлэлттэй байна.

/Хүснэгт №22/		/тэрбум төгрөг/	
д/д	Үзүүлэлт	Хөнгөлөлт, чөлөөлөлт	Эзлэх хувь
1	Аж ахуйн нэгжийн орлогын албан татварын тухай хууль	296.6	32.7
2	НӨАТ-ын тухай хууль, НӨАТ-аас чөлөөлөх тухай хууль	251.0	27.6
3	Гаалийн тариф, Гаалийн албан татварын тухай хууль, Гаалийн албан татвараас чөлөөлөх тухай хууль	45.7	5.0
4	Хувь хүний орлогын албан татварын тухай хууль	121.3	13.4
5	Онцгой албан татварын тухай хууль	193.7	21.3
НИЙТ ТАТВАРЫН ЗАРЛАГЫН ХЭМЖЭЭ		908.3	100.0

3.1.24 Гаалийн тариф, гаалийн татварын тухай хууль, Гаалийн албан татвараас чөлөөлөх тухай хууль, Нэмэгдсэн өртгийн албан татвараас чөлөөлөх тухай хуулиудын хүрээнд 2016 онд 1,436 иргэн, хуулийн этгээдийг импортын барааны гаалийн болон НӨАТ-аас чөлөөлжээ. Энэ нь өмнөх оноос 264 иргэн, хуулийн этгээдээр буурсан байна.

3.1.25 ААНОАТ-ын тухай хуулийн хүрээнд 451 хуулийн этгээд, НӨАТ-ын тухай хуулийн хүрээнд 2,987 хуулийн этгээд, ХХОАТ-ын тухай хуулийн хүрээнд давхардсан тоогоор 1.5 сая иргэн тус тус татварын хөнгөлөлт, чөлөөлөлтөд хамрагдсан байна.

3.2 Улсын төсвийн зарлага

3.2.1 Монгол Улсын 2016 оны төсвийн тухай хуулиар улсын төсвийн зарлагыг 5,920.1 тэрбум, уг хуульд 2016 оны 9 дүгээр сарын 9-нд оруулсан өөрчлөлтөөр 7,749.7 тэрбум төгрөгөөр баталсан нь анхны дүнгээс 1,829.6 тэрбум төгрөгөөр өссөн байна.

3.2.2 Энэ нь тайлант хугацаанд макро эдийн засгийн үндсэн үзүүлэлтүүдийн төсөөлөлд өөрчлөлт орсноос гадна төсвийн нэгдмэл байдлыг хангах зорилгоор төсвийн гадуур хэрэгжиж байсан төсөл хөтөлбөрийг төсвийн төсөлд тусгаж төлөвлөх бодлоготой холбоотойгоор хөрөнгийн зардлыг 479.1 тэрбум, эргэж төлөгдөх цэвэр зээлийн зардлыг 826.3 тэрбум төгрөгөөр нэмэгдүүлснээс шалтгаалжээ.

3.2.3 Тайлант онд улсын төсөв 7,394.2 тэрбум төгрөгийн буюу 95.4 хувийн гүйцэтгэлтэй гарч, төлөвлөснөөс 355.5 тэрбум төгрөгийн дутуу биелэлттэй байна.

/Хүснэгт № 23/

/тэрбум төгрөг/

ҮЗҮҮЛЭЛТ	2015 оны	2016 оны		
	гүйц	Төлөв	Гүйц	Зөрүү
Нийт зарлага ба цэвэр зээлийн дүн	4,996.9	7,749.7	7,394.2	(355.5)
А.Урсгал зардал	4,025.4	5,212.5	4,993.1	(219.4)
Бараа, үйлчилгээний зардал	1,639.6	2,085.1	1,951.0	(134.1)
Хүү	663.7	987.2	926.4	(60.8)
Татаас ба урсгал шилжүүлэг	1,722.1	2,140.2	2,115.7	(24.5)
Б.Хөрөнгийн зардал	950.7	1,909.0	1,893.3	(15.7)
В. Эргэж төлөгдөх цэвэр зээл	20.8	628.2	507.8	(120.4)

3.2.4 Нийт зарлагын 67.5 хувь буюу 4,993.1 тэрбум төгрөгийг урсгал зардалд, 25.6 хувь буюу 1,893.3 тэрбум төгрөгийг хөрөнгийн зардалд, 6.9 хувь буюу 507.8 тэрбум төгрөгийг эргэж төлөгдөх цэвэр зээлд зарцуулсан байна.

3.2.5 ТЕЗ-дын төсвийн гүйцэтгэлийг батлагдсан төсөвтэй харьцуулахад ЗТХС, ХЗДХС, ХХААХҮС, ЭХС-аас бусад ТЕЗ-дын төсвийн зардал хэтрээгүй буюу 91.9-99.8 хувийн гүйцэтгэлтэй байна.

/Хүснэгт № 24/

ТЕЗ	Зардлын ангилал	Төлөв	Гүйц	Зөрүү
Зам, тээврийн хөгжлийн сайд	Урсгал болон хөрөнгийн зардал	936.3	981.7	45.4
	Эргэн төлөгдөх төлбөрийг хассан цэвэр зээл	0.1		(0.1)
	ДҮН	936.4	981.7	45.3
Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн сайд	Урсгал болон хөрөнгийн зардал	141.6	136.5	(5.1)
	Эргэн төлөгдөх төлбөрийг хассан цэвэр зээл	(15.7)	5.7	21.4
	ДҮН	125.9	142.2	16.3
Хууль зүй, дотоод хэргийн сайд	Урсгал болон хөрөнгийн зардал	413.8	404.5	(9.3)
	Эргэн төлөгдөх төлбөрийг хассан цэвэр зээл	(22.2)		22.2
	ДҮН	391.6	404.5	12.9
Эрчим хүчний сайд	Урсгал болон хөрөнгийн зардал	109.9	101.9	(8.0)
	Эргэн төлөгдөх төлбөрийг хассан цэвэр зээл	16.8	27.4	10.6
	ДҮН	126.7	129.3	2.6

3.2.6 Харин дээрх нэр бүхий ТЕЗ-дын төсөв 2.1-12.9 хувиар хэтэрсэн нь дараах шалтгаантай байна. Тухайлбал,

- Хууль зүй, дотоод хэргийн сайдын 2016 оны төсвийн урсгал болон хөрөнгийн зардал төлөвлөснөөс 9.3 тэрбум төгрөгөөр хэмнэгдсэн боловч нийт дүнгээрээ 12.9 тэрбум төгрөгөөр хэтэрсэн нь Хадгаламж зээлийн хоршоодын хохирогчдод төсвөөс олгосон зээлийн 22.2 тэрбум төгрөгийг эргэн төлүүлэхээр төлөвлөснөөс шалтгаалжээ.
- ЗТХС-ын төсвийн зардал гүйцэтгэлээр 981.7 тэрбум төгрөг хүрч, батлагдсан төсвөөс 4.8 хувь буюу 45.3 тэрбум төгрөгөөр хэтэрсэн нь гадаад зээлийн эх үүсвэрээс санхүүжиж байгаа хөрөнгийг төсөвт тусгахдаа гадаад зээлийн өрийн тогтоосон хязгаартай уялдуулан өгсөн саналаас доогуур баталдаг бөгөөд бодит гүйцэтгэлээр зээлийн ашиглалт буюу гүйцэтгэл нь Сангийн ямаар дамжиж зээлийн гэрээний дагуу төсөл арга хэмжээний гүйцэтгэлээр санхүүждэгтэй холбоотой байна.
- ХХААХҮС-ын батлагдсан төсөв 12.9 хувь буюу 16.2 тэрбум төгрөгөөр хэтэрсэн нь ТЭДС-гаас эргэн төлөгдөхөөр төлөвлөгдсөн 24.0 тэрбум төгрөгийг барагдуулаагүйгээс шалтгаалсан байна.
- ЭХС-ын төсвийн нийт зардалд 126.7 тэрбум төгрөг батлагдсанаас 129.3 тэрбум төгрөгийн гүйцэтгэл гарч, батлагдсан төсвийг 2.3 тэрбум төгрөгөөр хэтрүүлсэн нь гадаад эх үүсвэрээр санхүүждэг төсөл хөтөлбөрийн зардалтай холбоотой байна.

3.2.7 Монгол Улсын 2016 оны төсвийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн 1 дүгээр хавсралтаар 31 төсвийн ерөнхийлөн захирагчийн тайлант онд хэрэгжүүлэх 86 хөтөлбөрт хамаарах 315 арга хэмжээ, тэдгээрийн хүрэх үр дүнгийн талаарх чанарын болон тоо хэмжээний үзүүлэлтийг баталсан байна.

3.2.8 Төсвийн ерөнхийлөн захирагч нар 2016 онд хэрэгжүүлсэн хөтөлбөр, арга хэмжээний хүрэх үр дүнг батлагдсан төсөв, гүйцэтгэлтэй харьцуулан тайлагнах асуудал хангалтгүй, Төсвийн тухай хуулийн 54 дүгээр зүйлийн 54.5¹⁸-д заасныг бүрэн хэрэгжүүлэхгүй байна.

3.2.9 Нэгтгэсэн хөтөлбөр, арга хэмжээ тус бүрийн батлагдсан төсөв, түүний гүйцэтгэлийг Төсвийн ерөнхийлөн захирагчдаар тайлагнасан боловч түүнд хөтөлбөр, арга хэмжээнд хамаарах төсөв, гүйцэтгэлийн дүнг арга хэмжээ тус бүрээр иж бүрэн гаргаж, нэгтгэн дүгнээгүй, судалгаанд хамрагдсан дийлэнх хөтөлбөр, арга хэмжээний биелэлтийн талаарх тайлбар хэт товч, 2016 оны зорилтот түвшний хэрэгжилт тасарсан шалтгааныг дурдаагүй зэрэг зөрчил нийтлэг байна.

3.2.10 Энэ нь Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.10.1, 12 дугаар зүйлийн 12.1.7-д заасан нэгдсэн төсвийн гүйцэтгэлийн тайланг улсын хэмжээнд нэгтгэж, тайлагнах чиг үүрэг, хариуцлага тодорхойгүй, хөтөлбөр, арга хэмжээний зорилтот түвшний биелэлт, үр дүнг нэгтгэж, тайлагнах Төсвийн ерөнхийлөн захирагчдын холбогдох газар, хэлтсийн ажлын уялдаа хангалтгүй байгаатай холбоотой байна.

3.2.11 Бүтцийн өөрчлөлтийн хөтөлбөрийг санхүүжүүлэхэд зориулж 4.2 тэрбум төгрөгийг төсвийн төсөлд тусгаж баталгаажуулснаас гүйцэтгэлээр 3.7 тэрбум төгрөгийг холбогдох Төсвийн ерөнхийлөн захирагч нарт шилжүүлэн зарцуулсан байна.

3.3 Улсын төсвийн тэнцэл

3.3.1 2016 онд улсын төсвийн нийт тэнцлийг 4.183.0 тэрбум төгрөгийн алдагдалтай байхаар төлөвлөж, гүйцэтгэлээр 3,499.8 тэрбум төгрөгийн алдагдалтай гарсан байна.

3.3.2 2016 оны улсын төсвийн алдагдлыг санхүүжүүлэх зорилгоор 4,830.1 тэрбум төгрөгийн ЗГҮЦ арилжаалж, 1,485.1 тэрбум төгрөгийн зээл авч ашиглаж, Хөгжлийн банкны 252.8 тэрбум төгрөгийн эх үүсвэрээр улсын төсвөөс эргэн төлөгдөх нөхцөлтэйгээр хөрөнгө оруулалтын ажлыг санхүүжүүлсэн, ХХС болон улсын төсөв хоорондын урьдчилгаа төлбөрөөс орлогод суутган тооцсонтой холбоотой 18.8 тэрбум төгрөгийг авлагаар бүртгэжээ.

3.3.3 Дээрх эх үүсвэрүүдээс ЗГҮЦ-ны эргэн төлөлтөд 1,548.2 тэрбум, Хөгжлийн банкны өөрийн хөрөнгийн эх үүсвэрийг нэмэгдүүлэхэд 1,000.0 тэрбум, зээлийн эргэн төлөлтөд 335.6 тэрбум төгрөгийг тус тус зарцуулж, үлдэх 3,499.8 тэрбум төгрөгөөр 2016 оны улсын төсвийн алдагдлыг санхүүжүүлснээр харилцах болон хадгаламжийн дансдын үлдэгдэл 203.2 тэрбум төгрөгөөр өссөн байна.

¹⁸ Төсвийн тухай хуулийн 54 дүгээр зүйлийн 54.5 “Төсвийн гүйцэтгэлийн тайлан нь дараах бүрэлдэхүүн хэсэгтэй байна”

54.5.1 “тухайн жилийн төсвийн орлого, зарлагын гүйцэтгэл, нийт дүнгээр, хөтөлбөрөөр, төсвийн захирагчаар, хөрөнгө оруулалтын арга хэмжээ бүрээр”

54.5.4 “хөтөлбөр, арга хэмжээнд зарцуулсан төсөв, хүрсэн үр дүн, түүний танилцуулга /хөтөлбөрийн гүйцэтгэлийн биелэлт, бодлогын зорилтын хэрэгжилт, түүний үр нөлөөнд хийсэн дүгнэлт, хөтөлбөрийн хүрээнд хэрэгжүүлсэн хөрөнгө оруулалтын арга хэмжээний биелэлт, тасарсан бол шалтгаан/”

БҮЛЭГ 4. ОРОН НУТГИЙН 2016 ОНЫ ТӨСӨВ

4.1 Орон нутгийн төсвийн орлого

4.1.1 Орон нутгийн 2016 оны төсвийн нийт орлого ба тусламжийн дүнг 2,188.6 тэрбум төгрөгөөр төлөвлөснөөс гүйцэтгэлээр 2,169.8 тэрбум төгрөгийн орлого төвлөрүүлж, төлөвлөгөө 99.1 хувийн биелэлттэй буюу 18.8 тэрбум төгрөгөөр орлогын төлөвлөгөө тасарсан байна. Хүснэгтээр үзүүлбэл:

/Хүснэгт № 25/

/тэрбум төгрөг/

Үзүүлэлт	2015 оны гүйцэтгэл	2016 оны			Эзлэх хувь /Гүйц/
		Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	
Нийт орлого ба тусламжийн дүн	2,033.6	2,188.6	2,169.8	(18.8)	100.0
Урсгал орлого	818.8	895.5	901.2	5.7	41.5
Татварын орлого	734.4	783.8	799.5	15.7	88.7
Татварын бус орлого	84.4	111.7	101.7	(10.0)	11.3
Хөрөнгийн орлого	39.3	13.5	1.2	(12.3)	0.1
Тусламжийн орлого	1,175.5	1,279.6	1,267.4	(12.2)	58.4

4.1.2 Орон нутгийн татварын орлого 2.0 хувиар буюу 15.7 тэрбум төгрөгөөр давж биелсэн ба татварын бус орлого 8.9 хувиар буюу 10.0 тэрбум, хөрөнгийн орлого 90.8 хувь буюу 12.3 тэрбум, тусламжийн орлого 1.0 хувиар буюу 12.2 тэрбум төгрөгөөр тасарсан байна.

4.1.3 Татварын бус орлогыг тасалдуулсан нь орон нутаг дахь зарим тусгай сангуудыг татан буулгаж, зарим сангуудын үйл ажиллагааны орлого, зарлагыг Төсвийн тухай хуулийн дагуу орон нутгийн төсвийн бүрэлдэхүүнд оруулан баталж, гүйцэтгэлийг тайлагнах болсноор сангуудаас олгосон зээлийн эргэн төлөлтийг зарим аймгууд төсөвт байгууллагын өөрийн орлогоор төлөвлөн баталсантай холбоотой байна.

4.1.4 ОНХНС-д Орхон, Өмнөговь аймаг 16.1 тэрбум төгрөгийг, улсын төсөвт Нийслэл, Өмнөговь, Орхон аймаг 74.5 тэрбум төгрөгийн орлогыг бүрэн төвлөрүүлж, Булган, Дорноговь аймгууд төлөвлөгөөг тасалсан байна.

4.1.5 Улсын төсвөөс орон нутгийн төсөвт 2016 онд санхүүгийн дэмжлэгээр 17 аймагт 150.9 тэрбум төгрөг, ОНХНС-ийн орлогын шилжүүлэг 120.3 тэрбум төгрөг, ТЗШ-ээр 995.3 тэрбум төгрөг олгосон байна.

4.1.6 Аймаг, нийслэлийн төсвийн 2016 оны орлогын төлөвлөгөө, гүйцэтгэлийг харуулбал:

/Хүснэгт № 26/

/тэрбум төгрөг/

Аймаг, нийслэл	Орлого				Аймаг, нийслэл	Орлого			
	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Хувь		Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Хувь
Архангай	64.4	64.1	(0.3)	99.5	Сүхбаатар	53.1	53.7	0.6	101.1
Баян-Өлгий	70.6	68.5	(2.1)	97.0	Сэлэнгэ	69.5	70.3	0.8	101.2
Баянхонгор	62.3	62.9	0.6	101.0	Төв	68.6	70.2	1.6	102.3
Булган	53.3	50.5	(2.8)	94.7	Увс	59.8	59.8	0.0	100.1
Говь-Алтай	53.8	52.4	(1.4)	97.3	Ховд	60.2	58.9	(1.3)	97.8
Дорноговь	53.2	50.8	(2.4)	95.4	Хөвсгөл	86.3	87.3	1.0	101.2
Дорнод	53.4	54.8	1.4	102.6	Хэнтий	56.4	56.7	0.3	100.5
Дундговь	40.6	39.8	(0.8)	98.0	Дархан-Уул	55.5	56.0	0.5	100.9
Завхан	57.5	59.1	1.6	102.8	Улаанбаатар	889.6	870.6	(19.0)	97.9
Өвөрхангай	70.5	71.0	0.5	100.7	Орхон	82.5	82.3	(0.2)	99.8
Өмнөговь	112.4	114.5	2.1	101.9	Говь-Сүмбэр	15.1	15.6	0.5	103.3
Нийт дүн						2,188.6	2,169.8	(18.8)	99.1

4.1.7 Төсвийн орлогын төлөвлөгөөг нийслэл болон 9 аймаг нийт 18.8 тэрбум төгрөгөөр дутуу төвлөрүүлсэн байна. Тухайлбал,

- Уул уурхайн компаниуд үйл ажиллагаагаа тогтмол явуулаагүй,
- Газрын төлбөрийн орлого дутуу төвлөрсөн нь дуудлага худалдаа зохион байгуулсан боловч оролцогч ирээгүй,
- Түгээмэл тархацтай ашигт малтмал болон ус рашаан ашигласны төлбөрийн орлого тасарсан зэргээс шалтгаалжээ.

4.1.8 Орлогын төлөвлөгөө тасарсан нь улс орны эдийн засгийн хүндрэлтэй байдлаас гадна өмч хувьчлалын, хүү торгуулийн, авто зам ашигласны, аж ахуйн нэгж байгууллагын ногдол ашгаас олох орлого төвлөрүүлэлтийн ажлыг хангалтгүй зохион байгуулсан, сум хөгжүүлэх сан болон бусад сангуудаас олгосон зээлийн төлбөрийг төсөвт байгууллагын өөрийн орлогод төлөвлөсөн зэрэгтэй холбоотой байна.

4.2 Орон нутгийн төсвийн зарлага

4.2.1 Орон нутгийн төсвийн 2016 оны нийт зарлага 2,441.9 тэрбум төгрөгөөр батлагдсанаас гүйцэтгэлээр 2,330.4 тэрбум төгрөг зарцуулж, 95.4 хувийн гүйцэтгэлтэй байна. Орон нутгийн төсвийн зарлагын гүйцэтгэлийг эдийн засгийн ангиллаар харуулбал:

/Хүснэгт № 27/		/тэрбум төгрөг/		
Үзүүлэлт	2015 оны гүйцэтгэл	2016 оны		
		Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү
Нийт зарлага ба цэвэр зээлийн дүн	2,079.1	2,441.9	2,330.4	(111.5)
А. Урсгал зардал	1,647.2	1,909.0	1,853.0	(56.0)
Бараа, ажил үйлчилгээний зардал	1,300.1	1,359.8	1,323.8	(36.0)
Хүү	0.0	-	-	-
Татаас	8.8	86.2	84.6	(1.6)
Урсгал шилжүүлэг	338.3	463.0	444.6	(18.4)
Б. Хөрөнгийн зардал	429.8	500.2	463.9	(36.3)
В. Эргэж төлөгдөх төлбөрийг хассан цэвэр зээл	2.1	32.7	13.5	(19.2)

4.2.2 Нийт зарлагын гүйцэтгэлийг өмнөх онтой харьцуулахад 251.3 тэрбум төгрөгөөр буюу 12.1 хувиар өссөн байна.

4.2.3 Орон нутгийн нэгдсэн төсвийн нийт зарлагын дүнд урсгал зардал 1,853.0 тэрбум төгрөг буюу 79.5 хувийг, хөрөнгийн зардал 463.9 тэрбум төгрөг буюу 19.9 хувийг, эргэж төлөгдөх төлбөрийг хассан цэвэр зээл 13.5 тэрбум төгрөг буюу 0.6 хувийг эзэлж байна.

4.2.4 Тайлант онд орон нутгийн төсвийн урсгал зардал нь өмнөх оноос 205.8 тэрбум төгрөгөөр өсч 1,853.0 тэрбум төгрөгийн гүйцэтгэлтэй байгаа ба үүнээс 764.3 тэрбум төгрөг буюу 41.2 хувийг цалин, 84.3 тэрбум төгрөг буюу 4.6 хувийг нийгмийн даатгалын шимтгэл, 475.2 тэрбум төгрөг буюу 25.6 хувийг бараа, ажил үйлчилгээний бусад зардал, 529.2 тэрбум төгрөг буюу 28.6 хувийг татаас, урсгал шилжүүлгийн зардал тус тус эзэлж байна.

4.2.5 Орон нутгийн ТЕЗ, түүний харьяа зарим байгууллагууд Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1¹⁹, 16 дугаар зүйлийн 16.5.5²⁰ дахь заалт, Засгийн газрын 2014 оны 147 дугаар тогтоолын холбогдох заалтыг бүрэн мөрдөөгүйгээс зарим аймаг, нийслэлийн хэмжээнд төсвийг үр ашигтай, зөв зохистой зарцуулаагүй байна. Тухайлбал,

¹⁹ төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах;

²⁰ батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах;

- Нийслэл-Хөрөнгө оруулалтын данснаас нийгмийн асуудал шийдвэрлэхэд 500.0 сая, барьцааны данснаас 133.0 сая, хөрөнгө бэлтгэхэд 8.8 сая төгрөгийг зориулалт бусаар зарцуулсан /НЗДТГ 633.0 сая, Багануур дүүргийн ЗДТГ 8.8 сая/,
- Хэвлэл, мэдээллийн байгууллагуудтай гэрээ байгуулж, хэвлэл, мэдээллийн хэрэгслээр сурталчилгаа хийхэд 904.7 сая төгрөгийг үрэлгэн зарцуулсан,
- Төсвөөс баяр ёслол, уралдаан тэмцээн, бэлэг дурсгал зэрэгт 163.0 сая төгрөг зарцуулж, үр ашиггүй зардал гаргасан,
- Шүүхийн шийдвэрээр нөхөн олговорт төсвөөс 158.9 сая төгрөг олгосон,
- Багануур дүүргийн ИТХ нь төлөөлөгч нарт 2015 оны 4 дүгээр улирлын урамшуулалд 69.2 сая төгрөгийг 2016 оны төсвөөс нөхөж олгосон,
- Говь-Алтай аймаг: Цалингийн урьдчилгааг суутгаагүй, цалин хөлс, үр дүнгийн урамшууллыг илүү тооцож олгосон, анхан шатны баримтгүйгээр албан томилолт, унаа, байр хоолны зардал, тэтгэмжид үндэслэлгүйгээр 147.5 сая төгрөг олгосон,
- Ажилчдын НДШ, ХХОАТ дутуу суутгасан зэрэг нийт 35.8 сая төгрөгийн зөрчил илэрсэн,
- Анхан шатны баримтгүйгээр, бүрдэл дутуу баримтаар 218.8 сая төгрөгийн зардал гаргасан,
- Ажлаас халагдсан ажилтанд Шүүхийн шийдвэрээр цалингийн нөхөн олговрыг олгосон бөгөөд буруутай этгээдээс нэхэмжлээгүй, байгууллагын төсвөөс 150.3 сая төгрөг олгосон,
- Орхон аймаг-Засаг даргын нөөц, хуваарилагдаагүй бусад зардлаас ТББ, иргэнтэй байгуулж гүйцэтгүүлсэн 15 гэрээний гүйцэтгэлийг дүгнэсэн акт үйлдээгүй 158.8 сая төгрөгийн урьдчилгаа олгож, түүний хүлээн авалтын зардалд 2.0 сая төгрөг зарцуулсан,
- Говьсүмбэр аймаг-Шүүхийн шийдвэрээр нийт 51.1 сая төгрөгийг олгохоор тооцогдож, тайлант хугацаанд 30.1 сая төгрөгийг олгож, төсвийг зориулалт бусаар зарцуулжээ.

4.2.6 Дээрх байдлаас үзвэл, орон нутгийн эрх бүхий байгууллагууд төсвийг үр ашигтай, арвилан хэмнэлттэй төлөвлөж батлах, зарцуулах зарчмыг баримтлаагүй байна.

4.3 Орон нутгийн төсвийн тэнцэл

4.3.1 2016 онд орон нутгийн төсвийн нийт тэнцлийг 253.4 тэрбум төгрөгийн алдагдалтай байхаар төлөвлөж, гүйцэтгэлээр 160.6 тэрбум төгрөгийн алдагдалтай гарсан нь өмнөх онтой харьцуулахад 115.2 тэрбум төгрөгөөр нэмэгджээ.

/Хүснэгт № 28/

/тэрбум төгрөг/

Үзүүлэлт	2015 оны гүйцэтгэл	Орон нутгийн 2016 оны төсвийн зарлага		
		Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү
Нийт тэнцэл	45.4	253.4	160.6	(92.8)
Алдагдлыг санхүүжүүлэх эх үүсвэр	45.4	253.4	160.6	(92.8)
Харилцах болон хадгаламжийн дансны цэвэр өөрчлөлт	41.0	216.8	95.7	(121.1)
Гадаад төслийн зээл	4.4	36.6	64.9	28.3

4.3.2 Орон нутгийн 2016 оны төсвийн нийт тэнцлийн алдагдлыг Засгийн газрын гадаад зээлээс 36.6 тэрбум төгрөгөөр, харилцах болон хадгаламжийн дансны үлдэгдэл 216.8 тэрбум төгрөгөөр санхүүжүүлэхээр төлөвлөж, гүйцэтгэлээр 64.9 тэрбум төгрөгийн гадаад зээл авч ашиглаж, тайлант оны эцэст орон нутгийн харилцах болон хадгаламжийн дансны үлдэгдэл 95.7 тэрбум төгрөгөөр буурсан байна.

4.3.3 2016 онд орон нутгийн төсвийн нийт тэнцэл 160.6 тэрбум төгрөгийн алдагдалтай гарахад Нийслэлийн төсөв 155.2 тэрбум, 11 аймгийн төсөв нийт 18.3 тэрбум төгрөгийн алдагдалтай гарсан нь нөлөөлжээ.

БҮЛЭГ 5. ХҮНИЙ ХӨГЖИЛ САНГИЙН 2016 ОНЫ ТӨСӨВ

5.1 Хүний хөгжил сангийн төсвийн орлого

5.1.1 Хүний хөгжил сангийн 2016 оны төсвийн тухай хуулиар 169.7 тэрбум төгрөгийн орлого төвлөрүүлэхээс 189.1 тэрбум төгрөг төвлөрч, төлөвлөгөөний биелэлт 111.4 хувьтай байна. Хүснэгтээр харуулбал,

/хүснэгт №29/		/тэрбум төгрөг/		
Ангилал		Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү
1. Нийт орлогын дүн		169.7	189.1	19.4
1.1.	Ашигт малтмалын нөөц ашигласны төлбөр	166.0	187.7	21.7
1.2.	Хувьцааны ногдол ашиг	3.0	-	-3.0
1.3	Бусад орлого /хадгаламжийн хүү/	0.7	-	-0.7
1.4	Бусад орлого	-	1.4	1.4

5.1.2 Хүний хөгжил сангийн тухай хуулийн 3 дугаар зүйлийн 3.2.2 -т заасан эх үүсвэр болох Ашигт малтмалын нөөц ашигласны төлбөрөөс 166.0 тэрбум төгрөгийн орлого төвлөрүүлэхээр батлагдсанаас 187.7 тэрбум төгрөг төвлөрч, төлөвлөснөөс 21.7 тэрбум төгрөг буюу 13.0 хувиар давж биелсэн байна.

5.1.3 Хүний хөгжил санд Хүний хөгжил сангийн тухай хуулийн 3 дугаар зүйлийн 3.2.1 -д заасан эх үүсвэрээс 3.0 тэрбум төгрөгийн орлого төвлөрүүлэхээр тооцсон боловч "Эрдэнэт үйлдвэр" ХХК-ийн ТУЗ-ийн хурал 2015, 2016 онд хуралдаагүй, ногдол ашиг хуваарилах шийдвэр гараагүйн улмаас дээрх орлого төвлөрөөгүй байна.

5.1.4 "Хүний хөгжил сангаас Монгол Улсын иргэнд 2016 онд хүртээх хишиг, хувийн хэмжээг тогтоох тухай" УИХ-ын 2015 оны 103 дугаар тогтоолоор 2019 оноос нөхөж олгох хүүхдийн мөнгөний санхүүжилтийн эх үүсвэрийг тухай бүр Засгийн газрын үнэт цаас гарган борлуулж, орлогыг банкинд хадгаламжаар байршуулахаар тогтоосон боловч хадгаламж байршуулж, хүүгийн орлого олоогүй байна.

5.2 Хүний хөгжил сангийн төсвийн зарлага

5.2.1 Тайлант онд Хүний хөгжил сангаас 223.2 тэрбум төгрөг зарцуулахаар батлагдсанаас 1,021,078 хүүхдэд 218.8 тэрбум төгрөг зарцуулж, 98.0 хувийн гүйцэтгэлтэй байна.

/хүснэгт №30/		/тэрбум төгрөг/		
Ангилал		Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү
1. Нийт зарлагын дүн		283.9	278.6	(5.3)
1.1.	Иргэдэд олгох бэлэн мөнгө /Хүүхдийн мөнгө/	223.2	218.8	(4.4)
1.2	ЗГҮЦ болон урьдчилгаа төлбөрийн хүүгийн зардал	60.7	59.8	(0.9)

5.2.2 Хүний хөгжил сангийн төсвийн дутагдлыг нөхөх, өрийг дахин санхүүжүүлэх зорилгоор гаргасан Засгийн газрын үнэт цаасны хүүгийн төлбөрт 59.8 тэрбум төгрөг төлж, 2016 оны эцсийн байдлаар 609.1 тэрбум төгрөгийн Засгийн газрын үнэт цаасны үлдэгдэлтэй байна.

5.2.3 Хүний хөгжил сангийн 2016 оны хүүгийн зардалд 44.9 тэрбум төгрөгийг төлж, Оюутолгой компанитай 14.9 тэрбум төгрөгийн хүүгийн зардлыг суутган тооцоо хийсэн байна.

5.3 Хүний хөгжил сангийн төсвийн тэнцэл

5.3.1 Хүний хөгжлийн сангийн 2016 оны нийт тэнцэл 114.2 тэрбум төгрөгийн алдагдалтай байхаар төлөвлөж, гүйцэтгэлээр 89.5 тэрбум төгрөгийн алдагдалтай гарсан байна. Алдагдлыг санхүүжүүлсэн эх үүсвэрийн бүтцийг авч үзвэл:

- Хүний хөгжил сангийн төсвийн алдагдлыг санхүүжүүлэхэд 228.1 тэрбум төгрөгийн үнэт цаасыг арилжаалж, үндсэн төлбөрт 177.4 тэрбум төгрөгийг төлсөн,
- Урьдчилгаа төлбөрийн суутган тооцооллоор 46.0 тэрбум төгрөгийг хорогдуулсан,
- Мөнгөн хөрөнгийн өөрчлөлтөөс 84.8 тэрбум төгрөг байна.

БҮЛЭГ 6. НИЙГМИЙН ДААТГАЛЫН САНГИЙН 2016 ОНЫ ТӨСӨВ

6.1 Нийгмийн даатгалын сангийн төсвийн орлого

6.1.1 Нийгмийн даатгалын сангийн орлогод 2016 онд 1,752.3 тэрбум төгрөг төлөвлөснөөс 1,809.9 тэрбум төгрөг төвлөрч, 103.3 хувийн гүйцэтгэлтэй гарсан байна.

6.1.2 Нийгмийн даатгалын сангийн 2016 оны төсвийн тухай хуулиар эрүүл мэнд, нийгмийн даатгалын шимтгэлийн орлого нийт 1,257.4 тэрбум төгрөг төвлөрүүлэхээр батлагдаж, гүйцэтгэлээр 1,315.0 тэрбум төгрөгийн орлого төвлөрүүлж, батлагдсан төлөвлөгөө 104.6 хувиар буюу 57.6 тэрбум төгрөгөөр давж биелсэн байна. Орлогын төрлөөр харуулбал:

/хүснэгт №31/		/тэрбум төгрөг/				
№	Орлогын төрөл	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Хувь	
1	Тэтгэврийн даатгал	743.8	767.8	24.0	103.2	
2	Тэтгэмжийн даатгал	82.8	86.8	4.0	104.8	
3	ҮОМШӨ-ний даатгал	106.7	125.2	18.5	117.3	
4	Ажилгүйдлийн даатгал	31.3	32.5	1.2	103.8	
5	Эрүүл мэндийн даатгал	292.8	302.7	9.9	103.4	
	Дүн	1,257.4	1,315.0	57.6	104.6	
6	Улсын төсвөөс санхүүжих	494.9	494.9	0.0	100.0	
	Нийт дүн	1,752.3	1,809.9	57.6	103.3	

6.1.3 2016 онд улсын төсвөөс өмнөх оны татаас санхүүжилтийн авлага 128.4 тэрбум, төрөөс хариуцдаг иргэдийн тэтгэврийн санхүүжилтэд 313.8 тэрбум, тэтгэврийн даатгалын сангийн алдагдлыг нөхөж 52.7 тэрбум төгрөг, нийт 494.9 тэрбум төгрөгийн санхүүжилт авсан байна.

6.1.4 Тайлант онд Нийгмийн даатгалын сангийн нийт 873.3 тэрбум төгрөгийн мөнгөн хөрөнгийн үлдэгдлээс 583.0 тэрбум төгрөгийг арилжааны банкинд байршуулсан нь өмнөх оноос 24.8 хувь буюу 116.0 тэрбум төгрөгөөр нэмэгдэж, нийт мөнгөн хөрөнгийн 66.8 хувийг эзэлж байна.

6.1.5 Тайлант онд харилцах дансны үлдэгдэл, хадгаламж, бондын хүүгээс 72.6 тэрбум төгрөгийн орлого төвлөрүүлжээ.

6.1.6 Хүүгийн орлогын судалгааг сан тус бүрээр харуулбал,

/Хүснэгт № 32/		/тэрбум төгрөг/				
№	Сангийн төрөл	Харилцах дансны үлдэгдлийн хүү	Хадгаламжийн хүү	Бондын хүү	Хүүгийн орлогын нийт дүн	Хувь
1	Тэтгэврийн даатгал	1.2	-	-	1.2	1.7
2	Тэтгэмжийн даатгал	0.3	-	-	0.3	0.4
3	ҮОМШӨ-ний даатгал	4.2	20.1	3.6	27.9	38.4
4	Ажилгүйдлийн даатгал	0.9	7.6	2.8	11.3	15.6
5	Эрүүл мэндийн даатгал	1.2	23.8	6.9	31.9	43.9
	Дүн	7.8	51.5	13.3	72.6	100.0

6.1.7 Нийгмийн даатгалын сангийн чөлөөт үлдэгдлээс арилжааны банкуудад байршуулж буй хадгаламжийн хүүг Монголбанкны бодлогын хүүтэй уялдуулан цаг тухай бүрт нь өөрчлөлт оруулж байх шаардлагатай байна.

6.2 Нийгмийн даатгалын сангийн төсвийн зарлага

6.2.1 Нийгмийн даатгалын сангийн 2016 оны төсвийн тухай хуулиар нийт зарлагыг 1,764.7 тэрбум төгрөгөөр баталж, нийт гүйцэтгэлээр 1,720.5 тэрбум төгрөгийг зарцуулж, батлагдсан төсвийг 44.2 тэрбум төгрөгөөр хэмнэсэн байна. Үүнээс: Нийгмийн даатгалын ерөнхий газрын

урсгал төсвийг 19.9 тэрбум төгрөгөөр баталж, гүйцэтгэлээр 20.0 тэрбум төгрөгийг зарцуулж, батлагдсан төсвийг 0.1 тэрбум төгрөгөөр хэтрүүлсэн байна.

6.2.2 2016 онд Нийгмийн даатгалын сангаас давхардсан тоогоор 6,295 мянган иргэний тэтгэвэр, тэтгэмж, төлбөр, эрүүл мэндийн тусламж үйлчилгээний зардалд нийт 1,720.5 тэрбум төгрөгийг зарцуулжээ. Зардлын гүйцэтгэлийг харуулбал,

/хүснэгт № 33 /

/тэрбум төгрөг/

	Ангилал	2015 оны		2016 он		
		гүйцэтгэл	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Хувь
1	Тэтгэврийн даатгал	1,191.9	1,320.6	1,320.6	0.0	100.0
2	Тэтгэмжийн даатгал	89.5	104.8	94.1	(10.7)	89.8
3	ҮОМШӨ-ний даатгал	33.5	39.7	31.0	(8.7)	78.1
4	Ажилгүйдлийн даатгал	23.4	28.1	32.0	3.9	113.9
5	Эрүүл мэндийн даатгал	203.1	271.5	242.8	(28.7)	89.4
	ДҮН	1,541.4	1,764.7	1,720.5	(44.2)	97.5

6.2.3 2016 онд батлагдсан төсвийг нийт дүнгээр 2.5 хувь буюу 44.2 тэрбум төгрөгөөр хэмнэсэн ба тэтгэврийн болон ажилгүйдлийн даатгалын сангаас бусад сангууд батлагдсан төлөвлөгөөг 10.2 - 21.9 хувиар хэмнэсэн үзүүлэлттэй байна.

6.2.4 2016 онд тэтгэврийн даатгалын сан 42.6 тэрбум төгрөгийн алдагдалтай ажиллаж, улсын төсвөөс алдагдлыг нөхөж санхүүжүүлсэн байна. Тэтгэврийн даатгалын сангийн алдагдал 2014 онд 26.9 тэрбум төгрөг, 2015 онд өмнөх оноос 6 дахин нэмэгдэж, 161.1 тэрбум төгрөгт хүрсэн бол 2016 онд өмнөх оноос 3.8 дахин буурч 42.6 тэрбум төгрөг болсон байна.

6.2.5 Тэтгэврийн даатгалын сан нь 2014 - 2016 онуудад алдагдалтай ажиллахад дараах зүйлүүд голлох нөлөөллийг үзүүлсэн байна. Үүнд:

- Ажилласан жил, тэтгэврийн даатгалын шимтгэлийг нөхөн тооцох тухай хууль, Нийгмийн даатгалын тухай хуулийн нэмэлт өөрчлөлт, "Тэтгэвэр нэмэгдүүлэх, тэтгэвэр бодох цалингийн итгэлцүүр, тэтгэврийн доод хэмжээг шинэчлэн тогтоох тухай" Засгийн газрын 2014 оны 15, 2015 оны 52, 2016 оны 292 дугаар тогтоолуудын дагуу иргэдийн тэтгэврийг нэмэгдүүлэн тэтгэврийн доод хэмжээ 140.3-251.0 мянган төгрөг, хувь тэнцүүлсэн тэтгэврийн доод хэмжээ 105.2-216.0 мянган төгрөг, дундаж тэтгэвэр 162.0-310.7 мянган төгрөгт хүрч тус тус нэмэгдсэн.
- Тэтгэврийн даатгалын сангаас 2014 онд 338.8 мянган тэтгэвэр авагчид 984.8 тэрбум, 2015 онд 356.7 мянган тэтгэвэр авагчид 1,171.9 тэрбум төгрөг, 2016 онд 363.8 мянган тэтгэвэр авагчид 1,320.6 тэрбум төгрөг зарцуулж, тус сангийн зарлага 14.3-21.5 хувиар өссөн.
- Мөн уг сангаас зарцуулсан үйл ажиллагааны зардал болон хөрөнгө оруулалтын зардлын санхүүжилт тайлант онд 15.1 тэрбум төгрөгт хүрч, өмнөх оноос 4.2 тэрбум төгрөгөөр нэмэгдсэн нь нөлөөлжээ.

6.2.6 Тайлант онд ажилгүйдлийн даатгалын сангийн зарлага батлагдсан төсвөөс 3.9 тэрбум төгрөгөөр хэтэрч зарцуулагдсан байна. Энэ нь тайлант онд ажилгүйдлийн тэтгэмж авсан иргэдийн тоо 23.2 мянга болж, өмнөх оноос 4.5 мянгаар нэмэгдсэнтэй холбоотой байна.

6.2.7 Ажилгүйдлийн даатгалын сангийн зарцуулалтыг хүснэгтээр харуулбал,

/Хүснэгт №34/

/сая төгрөг/

Д/д	Зардлын төрөл	2015 он				2016 он			
		Хүний тоо	Төлөв	Гүйц	Хувь	Хүний тоо	Төлөв	Гүйц	Хувь
1	Ажилгүйдлийн тэтгэмж		24,459.2	22,373.9	91.5		27,545.4	31,578.1	114.6
2	Шүүхийн шийдвэр		4.8	1.2	25.0		4.8	2.1	43.7
3	Сургалтын зардал		192.0	0.0	0.0		96.0	0.0	0.0
4	Үйл ажиллагааны зардал		615.9	630.6	102.4		377.1	373.1	98.9

5	Хөрөнгө оруулалт		402.9	388.5	96.4		55.5	56.4	101.6
6	Бусад зардал		60.0	19.3	32.2		60.0	31.9	53.2
		18,698	25,734.8	23,413.5	91.0	23,203	28,138.8	32,041.6	113.9

6.2.8 2016 онд НДС-гаас хөрөнгө оруулалтад 3.0 тэрбум төгрөг зарцуулахаар төлөвлөж, гүйцэтгэлээр 2.9 тэрбум төгрөг зарцуулж, батлагдсан төсвөөс 0.1 тэрбум төгрөгийг дутуу зарцуулсан, дээд шатны төсвийн ерөнхийлөн захирагчийн төсвөөс нэмэлт санхүүжилтээр 2.4 тэрбум төгрөгийн хөрөнгө оруулалтын санхүүжилт олгосноос 1.4 тэрбум төгрөгийн хөрөнгө оруулалтын ажил хэрэгжээгүй боловч санхүүжилтийг гүйцэтгэгч байгууллагын нэр дээрх дундын дансанд байршуулсан байна. Тайлант оны нийт хөрөнгө оруулалтын ажлын гүйцэтгэл 72.2 хувьтай байна.

6.3 Нийгмийн даатгалын сангийн төсвийн тэнцэл

6.3.1 Нийгмийн даатгалын сангийн төсвийн нийт тэнцлийг 2016 онд 12.4 тэрбум төгрөгийн алдагдалтай төлөвлөж, гүйцэтгэлээр 89.6 тэрбум төгрөгийн ашигтай гарч, сангийн мөнгөн хөрөнгийн үлдэгдэл өссөн байна.

БҮЛЭГ 7. НЭМЭЛТ ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ

7.1 Тайлант онд нэмэлт төсвөөр 274.5 тэрбум төгрөгийн эх үүсвэр төвлөрсөн нь өмнөх оныхоос 5.0 тэрбум төгрөгөөр нэмэгдсэн байна. Нэмэлт санхүүжилтийн төвлөрсөн эх үүсвэрийг Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.1-д²¹ зааснаар ангилан харуулбал:

- Дээд шатны төсөв захирагчаас доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө 100.2 тэрбум төгрөг,
- Төрийн болон орон нутгийн өмчит бус этгээдээс авсан хандив тусламжаар 27.4 тэрбум төгрөг,
- Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого 78.9 тэрбум төгрөг,
- Засгийн газрын болон Засаг даргын нөөцөөс /давхардсан дүнгээр/ 60.2 тэрбум төгрөг,
- УИХ-аас баталсан Засгийн газар хоорондын гэрээ болон Олон улсын байгууллагаас авах хөнгөлөлттэй зээл 0.7 тэрбум төгрөг,
- Төсвийн урамшууллаас 7.1 тэрбум төгрөг тус тус төвлөрсөн байна.

7.2 Нэмэлт төсвөөр 2016 онд бүрдүүлсэн эх үүсвэр болон мөнгөн хөрөнгийн эхний үлдэгдлээс нийт 279.9 тэрбум төгрөгийг зарцуулснаас улсын төсөвт байгууллагууд 217.2 тэрбум төгрөг буюу 77.6 хувь, орон нутгийн төсөвт байгууллагууд 62.7 тэрбум төгрөг буюу 22.4 хувийг тус тус эзэлж байна. Нэмэлт төсвийн зарлагын гүйцэтгэлийг хүснэгтээр харуулбал:

/Хүснэгт №35/

/тэрбум төгрөг/

Үзүүлэлт	Тайлант оны гүйцэтгэл		
	Улсын төсөв	Орон нутгийн төсөв	Нийт дүн
Нийт зарлага ба цэвэр зээлийн дүн	217.2	62.7	279.9
Урсгал зардал	200.4	54.4	254.8
Бараа, ажил үйлчилгээний зардал	171.9	48.3	220.2
Татаас	0.1	0.4	0.5
Урсгал шилжүүлэг	28.4	5.7	34.1
Хөрөнгийн зардал	16.8	8.3	25.1
Зардлыг санхүүжүүлэх эх үүсвэр	211.7	62.8	274.5
Нийт цэвэр мөнгөн гүйлгээ	5.5	0.2	5.7
Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	18.0	0.1	18.1
Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	12.5	0.2	12.7

7.3 Нэмэлт төсвөөс бараа, ажил үйлчилгээний зардалд нийт 220.2 тэрбум төгрөг зарцуулснаас эд хогшил, урсгал засварт 18.9 тэрбум, томилолт, зочны зардалд 39.1 тэрбум, бусдаар гүйцэтгүүлсэн ажил үйлчилгээний төлбөр хураамжийн зардалд 47.6 тэрбум, бараа, ажил үйлчилгээний бусад зардалд 114.6 тэрбум төгрөгийг тус тус зарцуулсан байна.

7.4 Улсын төсвийн ерөнхийлөн захирагчдын нэмэлт төсвийн 23.3 хувь буюу 50.7 тэрбум, төгрөгийг БХС, 14.1 хувь буюу 30.5 тэрбум төгрөгийг ХХААХҮС, 11.1 хувь буюу 24.1 тэрбум төгрөгийг ХЗДХС, 9.2 хувь буюу 20.0 тэрбум төгрөгийг ЭХС, үлдэх 42.3 хувь 91.9 тэрбум төгрөгийг бусад 29 ТЕЗ зарцуулсан байна.

7.5 Орон нутгийн нэмэлт төсвийн нийт зарцуулалтын 40.3 хувь буюу 25.3 тэрбум төгрөг Улаанбаатар хотод, 5.1 хувь буюу 3.2 тэрбум төгрөг Өмнөговь аймагт, 4.0 хувь буюу 2.5 тэрбум төгрөг Увс аймагт, 3.2 хувь буюу 2.0 тэрбум төгрөг Сэлэнгэ аймагт, үлдэх 47.4 хувь буюу 29.7 тэрбум төгрөг бусад аймагт ногдож байна.

²¹ 47.1. “Төсвийн захирагч нь дараах нэмэлт төсвийг холбогдох төсөл, арга хэмжээнд зарцуулж болно”

ДҮГНЭЛТ

Монгол Улсын 2016 оны нэгдсэн төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын дүнд үндэслэн дараах дүгнэлтийг хийж байна. Үүнд:

1. Эрдэс баялгийн бүтээгдэхүүний үнийн бууралт, хөрш орны эдийн засгийн хэлбэлзэл, уул уурхайн бүтээгдэхүүний үнийн бууралт зэрэг гадаад хүчин зүйлсээс гадна ханшийн өөрчлөлт, тус тусдаа олон төсөв, гадаад зээлийн төлбөрийн дарамт, төсөв мөнгөний бодлогын уялдаа хамаарал хангалтгүй байсан зэрэг дотоод хүчин зүйлсийн сөрөг нөлөөлөл нь Засгийн газрын санхүүгийн эмзэг байдлыг бий болгосон байна.
2. Макро эдийн засгийн төсөөлөл, гадаад, дотоод хүчин зүйлсийг үндэслэлтэй тооцоолохгүйгээр дунд хугацаанд баримтлах Төсвийн хүрээний мэдэгдлийг боловсруулж, баталж байгаа нь уг баримт бичгийг богино хугацаанд өөрчлөх, төсвийн тогтвортой байдлын талаарх хуулийн шаардлага хангагдахгүй байх нөхцөлийг бүрдүүлж байна.
3. Нэгдсэн төсвийн төслийг боловсруулах, төсөвт тодотгол, нэмэлт өөрчлөлт оруулахдаа өмнө батлагдсан суурь тооцооллыг өөрчилж байгаа нь төсөв хэлбэлзэх эрсдэлийг бий болгож байна.
4. Тайлант онд экспортод гаргасан гол нэр төрлийн эрдэс баялгийн бүтээгдэхүүний биет хэмжээ өмнөх оноос 89.8 мянган, төлөвлөснөөс 36.9 мянган тн-оор тус тус нэмэгдсэн боловч зэсийн зах зээлийн үнэ 2016 оны турш тэнцвэржүүлсэн үнээс дунджаар 5.3 хувиар доогуур байснаас Тогтворжуулалтын санд орлого төвлөрөөгүй байна.
5. Өмнөх онтой харьцуулахад “Эрдэнэт үйлдвэр” ХХК-ийн үйлдвэрлэж борлуулсан цэвэр зэс 12.4 мянган тн, зэсийн баяжмал 62.4 мянган тн-оор тус тус нэмэгдсэн боловч төсөвт төвлөрүүлсэн татварын орлого 2.8 дахин буюу 207.1 тэрбум төгрөгөөр буурсан байна.
6. Татварын зарлага 908.3 тэрбум төгрөг буюу нийт тэнцвэржүүлсэн орлогын 15.6 хувьд хүрч, өмнөх оны мөн үеэс 251.5 тэрбум төгрөг буюу 38.3 хувиар өссөн байна.
7. Өмнөх жилүүдэд төсвөөс эргэж төлөх нөхцөлөөр төсвийн гадуур хэрэгжүүлсэн хөрөнгө оруулалтын зардлыг төсөвт тусгасан, урьдчилан тооцоолоогүй хөтөлбөрүүдийг өр үүсгэж хэрэгжүүлсэн зэргээс шалтгаалан нэгдсэн төсвийн нийт зарлага ба цэвэр зээлийн гүйцэтгэл ДНБ-ийн нийт дүнтэй харьцуулахад 39.8 хувьд хүрсэн байна.
8. Засгийн газрын өр өмнөх оноос 7,964.2 тэрбум төгрөгөөр өсөхөд гадаад өр 5,299.3 тэрбум, дотоод үнэт цаас 2,155.6 тэрбум төгрөгөөр өссөнөөс гадна улс, орон нутгийн төсвөөс эргэж төлөгдөх нөхцлөөр гэрээ байгуулсан концессын өр 2.6 дахин буюу 407.9 тэрбум, векселийн өр 1.9 дахин буюу 142.9 тэрбум төгрөгөөр нэмэгдсэн нь нөлөөлжээ.
9. Гадаад өрийн өсөлтийн 56.1 хувь буюу 2,975.8 тэрбум төгрөгийг ханшийн зөрүү эзэлж байна.
10. Нэгдсэн төсвийн 2016 оны нийт алдагдал ДНБ-ийн 15.3 хувьтай тэнцэж, алдагдлыг санхүүжүүлсэн өрийн өсөлттэй холбоотойгоор хүүгийн зардал 986.1 тэрбум төгрөгт хүрч, нийт зарлагын 10.4 хувьтай тэнцэж байгаа нь Монгол Улс төсвийн болон төлбөрийн чадварын эрсдэлд орж, өрийг өрөөр аргацаахад хүрсэн байна.
11. Төсвийг хөтөлбөрөөр төлөвлөж, үр дүнг тооцож хэрэгжүүлэх үйл ажиллагаа жигд бус, төлөвлөлт, бүртгэл тооцоо, тайлагналын програм хангамжийн уялдаа хангалтгүй байгаагаас Төсвийн ерөнхийлөн захирагчдын төсвийн гүйцэтгэлийн тайлагнал, хөтөлбөрийн хэрэгжилттэй уялдахгүй байна.
12. Тухайн жилийн орон нутгийн төсөвт тодотгол, нэмэлт өөрчлөлт оруулах, эцэслэн батлах хугацааг хуулиар тогтоогоогүйгээс Аймаг, нийслэл, сум, дүүргийн Төсвийн ерөнхийлөн захирагч нар Төсвийн тухай хуульд заасан нөхцөл, шаардлагыг баримтлахгүйгээр төвлөрсөн орлогын хэмжээтэй уялдуулан зарлагыг нэмэгдүүлж, төсөвт өөрчлөлт оруулж байгаа нь улсын хэмжээнд тайлан тооцоог нэгтгэх, хянахад сөргөөр нөлөөлж, нэгдсэн төсвийн алдагдал нэмэгдэх, төсвийн нэгдмэл байдлыг хангах зарчим алдагдахад хүргэж байна.
13. Орон нутагт төсвийн зардлын хэмнэлтээс үүссэн эх үүсвэрийг дараагийн төсвийн жилд бусад зардалд шилжүүлэн санхүүжүүлж байгаа нь орон нутгийн төсвийн зардал нэмэгдэх нөхцөлийг бүрдүүлж байна.

Монгол Улсын Их Хурлын анхааралд толилуулах нь:

Засгийн газраас ирүүлсэн Монгол Улсын 2016 оны нэгдсэн төсвийн гүйцэтгэлийн тайланд тусгасан 5,835.0 тэрбум төгрөгийн орлого, 9,495.3 тэрбум төгрөгийн зарлагын гүйцэтгэлийг аудитаар баталгаажууллаа.

Үүний зэрэгцээ дараах асуудлуудыг толилуулж байна. Тухайлбал,

1. Монгол Улсын нэгдсэн төсөв батлах, төсвийн тодотгол болон нэмэлт өөрчлөлт хийх бүрт Төсвийн тогтвортой байдлын тухай хуульд өөрчлөлт оруулж байгаа нь төсвийн тогтвортой байх хуулийн шаардлагыг хангахгүй байна.
2. Жилийн дундуур тухайн оны төсөвт нөлөөлөх бодлогын шийдвэр гаргахгүй байх хуулийн шаардлага хангагдахгүй байна.
3. Монгол Улсын нэгдсэн төсөвт тодотгол, нэмэлт өөрчлөлт хийгдсэний дараа орон нутгийн төсөвт тодотгол, нэмэлт өөрчлөлт оруулах хугацааг тодорхой тогтоосон цаглабарын нарийвчилсан зохицуулалтыг Төсвийн тухай хуульд бий болгох,
4. Төсвийн тухай хуульд орон нутгийн төсвийг батлах, хэрэгжүүлэхдээ алдагдалгүй байхаар заасан боловч орон нутгийн төсвийн урьд оны үлдэгдлээс санхүүжүүлэх зардлыг төсөвт тусган хэрэгжүүлэх боломжтой байгаа нь хоорондоо зөрчилдөж буй тул хуулийн зохицуулалтыг боловсронгуй болгох,
5. Төв болон орон нутгийн төсөв хоорондын харилцаа, Аймаг, нийслэл, сум, дүүргийн Төсвийн ерөнхийлөн захирагчдын эрх хэмжээ зэрэг асуудлыг нарийвчлан судалж, төсвийн сахилга бат, хариуцлагыг дээшлүүлэх чиглэлээр эрх зүйн шинэчлэл хийх шаардлага бий болсон байна.

ЗӨВЛӨМЖ

Аудитын дүн, дүгнэлтэд үндэслэн дараах арга хэмжээг авч хэрэгжүүлэхийг дор дурдсан албан тушаалтанд зөвлөж байна. Үүнд:

Монгол Улсын Ерөнхий сайд-д

1. Төсвийн орлогын төлөвлөлтийг үндэслэлгүйгээр нэмэгдүүлэхгүй байх, төсвийн тогтвортой, нэгдмэл байдлыг хангахад анхаарч, бүх шатны төсвийн төслийг боловсруулах, хэрэгжүүлэхэд хууль, тогтоол, дүрэм, журмын шаардлагыг мөрдөх, хариуцлага тооцох механизмыг сайжруулах, үр дүнг тооцох;
2. Жилийн дундуур төсөвт нөлөөлөх талаар гаргасан бодлогын шийдвэрийг дараагийн жилээс хэрэгжүүлдэг байхаар хууль, эрх зүйн орчинг сайжруулах;
3. Тухайн жилийн төсвийн тухай хуулиар хүлээсэн үүргээ биелүүлээгүй, төсвийн орлогыг үндэслэлгүйгээр дутуу төвлөрүүлсэн зарим орон нутгийн Төсвийн ерөнхийлөн захирагч болон төсвийн байгууллагын удирдлагатай хариуцлага тооцох;
4. Төсвийн зардлыг бууруулах, алдагдлыг нэмэгдүүлэхгүй байхад анхаарч, сахилга хариуцлагыг дээшлүүлэх;
5. “Эрдэнэт үйлдвэр” ХХК-ийн 2016 оны эдийн засаг, санхүү, татварын үйл ажиллагаанд дотоод аудит хийж, бодитой дүгнэлт гаргах, зардал зүй бусаар нэмэгдүүлсэн, татварын болон бусад хууль зөрчсөн албан тушаалтантай хариуцлага тооцох.

Сангийн сайд-д

1. Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, тайлагналын програм хоорондын мэдээлэл солилцох боломж нөхцөлийг нэмэгдүүлэх замаар төлөвлөлт, санхүүжилт, тайлан бүртгэлийн мэдээллийн системүүдийн ач холбогдол, үр нөлөөг дээшлүүлэх, тэдгээрийн уялдааг хангах ажлыг эрчимжүүлэх;
2. Татварын хөнгөлөлт, чөлөөлөлт /зарлага/-ийн одоогийн нөхцөл байдалд судалгаа шинжилгээ хийж, эдийн засгийн хөшүүргийн хувьд оновчтой, үр нөлөөтэй болгох чиглэлээр бодлогын шинэчлэл хийх асуудлыг боловсруулж, шийдвэрлүүлэх;
3. Төсвийн ерөнхийлөн захирагч нарын хөтөлбөрт суурилсан төсөвлөлт, батлагдсан хөтөлбөр арга хэмжээний хэрэгжилт, төсвийн гүйцэтгэл, тайлагналтай холбоотой чиг үүрэг, үйл ажиллагааг нэгтгэх, тайлагнах бодлого, арга зүйг тодорхойлж, эрх зүйн актаар баталгаажуулах;
4. Аймаг, нийслэлийн Төсвийн ерөнхийлөн захирагчид Төсвийн тухай хуульд заасан орон нутгийн төсвийг алдагдалгүй баталж, хэрэгжүүлэх зарчмыг мөрдөхгүй байгааг анхаарч, орон нутгийн тухайн жилийн төсвийн төсөл болон төсвийн тодотголыг батлах, гүйцэтгэлийг хэрэгжүүлэх харилцааг боловсронгуй болгох талаар холбогдох хуулийн зохицуулалтыг өөрчлөх санал боловсруулж, шийдвэрлүүлэх.

Хавсралт №1

/сая төгрөгөөр/

МОНГОЛ УЛСЫН 2016 ОНЫ НЭГДСЭН ТӨСВИЙН ОРЛОГЫН ГҮЙЦЭТГЭЛ

ҮЗҮҮЛЭЛТ	Нэгдсэн			Улсын			О Нутаг			ХХС			НДС		
	Төлөв	Гүйц	Зөрүү	Төлөв	Гүйц	Зөрүү	Төлөв	Гүйц	Зөрүү	Төлөв	Гүйц	Зөрүү	Төлөв	Гүйц	Зөрүү
НИЙТ ОРЛОГО БА ТУСЛАМЖИЙН ДҮН	5,429,139.9	5,835,043.8	405,903.9	3,566,591.4	3,894,443.3	327,851.9	2,188,596.8	2,169,796.5	-18,800.3	169,703.4	189,095.1	19,391.6	1,752,427.5	1,809,912.2	57,484.7
НИЙТ ТЭНЦЭРЖҮҮЛСЭН ОРЛОГО БА ТУСЛАМЖИЙН ДҮН	5,429,139.9	5,835,043.8	405,903.9	3,566,591.4	3,894,443.3	327,851.9	2,188,596.8	2,169,796.5	-18,800.3	169,703.4	189,095.1	19,391.6	1,752,427.5	1,809,912.2	57,484.7
1. Татварын орлого	4,532,399.4	4,950,950.2	418,550.9	2,533,795.9	2,854,078.6	320,282.6	783,754.1	799,450.1	15,696.0	166,004.7	187,664.2	21,659.5	1,257,548.4	1,315,033.1	57,484.7
1.1. Орлогын албан татвар	955,289.1	1,043,368.7	88,079.6	433,900.0	519,958.7	86,058.7	521,389.1	523,410.0	2,020.9	0.0	0.0	0.0	0.0	0.0	0.0
1.1.1. Хувь хүний орлогын албан татвар	521,389.1	523,410.0	2,020.9	0.0	0.0	0.0	521,389.1	523,410.0	2,020.9	0.0	0.0	0.0	0.0	0.0	0.0
1.1.2. Аж, ахуйн нэгж байгууллагын орлогын албан татвар	433,900.0	519,958.7	86,058.7	433,900.0	519,958.7	86,058.7	0.0	0.0	0.0	0.0	0.0	0.0	0.0	0.0	0.0
1.2. Нийгмийн даатгалын шимтгэл, хураамж	1,048,844.6	1,109,757.4	60,912.8	0.0	0.0	0.0	0.0	0.0	0.0	0.0	0.0	0.0	1,257,548.4	1,315,033.1	57,484.7
1.3. Хөрөнгийн албан татвар	98,777.2	104,659.9	5,882.7	0.0	0.0	0.0	98,777.2	104,659.9	5,882.7	0.0	0.0	0.0	0.0	0.0	0.0
1.4. Нэмэгдсэн ертийн албан татвар	1,081,358.1	1,140,721.4	59,363.3	1,081,358.1	1,140,721.4	59,363.3	0.0	0.0	0.0	0.0	0.0	0.0	0.0	0.0	0.0
1.5. Онцгой албан татвар	531,836.1	630,124.8	98,288.7	531,836.1	630,124.8	98,288.7	0.0	0.0	0.0	0.0	0.0	0.0	0.0	0.0	0.0
1.6. Тусгай зориулалтын орлого	8,583.0	10,767.4	2,184.4	8,583.0	10,767.4	2,184.4	0.0	0.0	0.0	0.0	0.0	0.0	0.0	0.0	0.0
1.7. Гадаад үйл ажиллагааны орлого	302,214.0	328,490.6	26,276.7	302,214.0	328,490.6	26,276.7	0.0	0.0	0.0	0.0	0.0	0.0	0.0	0.0	0.0
1.8. Бусад татвар (төлбөр, хураамж)	505,497.2	583,060.0	77,562.7	175,904.7	224,015.6	48,110.8	163,587.8	171,380.2	7,792.4	166,004.7	187,664.2	21,659.5	0.0	0.0	0.0
2. Татварын бус орлого	896,740.5	884,093.5	-12,647.0	1,032,795.5	1,040,364.8	7,569.3	1,404,842.6	1,370,346.4	-34,496.3	3,698.8	1,430.9	-2,267.8	494,879.0	494,879.0	0.0
2.1. Нийтлэг татварын бус орлого	770,918.7	805,424.9	34,506.1	655,525.1	702,241.3	46,716.2	111,694.9	101,752.7	-9,942.2	3,698.8	1,430.9	-2,267.8	0.0	0.0	0.0
2.2. Хөрөнгийн орлого	13,746.5	1,487.3	-12,259.2	213.4	253.8	40.4	13,533.1	1,233.5	-12,299.6	0.0	0.0	0.0	0.0	0.0	0.0
2.3. Тусламжийн орлого	112,075.3	77,181.3	-34,894.0	377,057.0	337,869.7	-39,187.3	1,279,614.6	1,267,360.2	-12,254.4	0.0	0.0	0.0	494,879.0	494,879.0	0.0

Хавсралт №2

МОНГОЛ УЛСЫН 2016 ОНЫ НЭГДСЭН ТӨСВИЙН ЗАРЛАГЫН ГҮЙЦЭТГЭЛ

/сая төгрөгөөр/

ҮЗҮҮЛЭЛТ	Нэгдсэн			Улсын			О Нутаг			ХХС			НДС		
	Төлөв	Гүйц	Зөрүү	Төлөв	Гүйц	Зөрүү	Төлөв	Гүйц	Зөрүү	Төлөв	Гүйц	Зөрүү	Төлөв	Гүйц	Зөрүү
НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	9,992,153.1	9,495,332.9	-496,820.2	7,749,656.3	7,394,235.5	-355,420.8	2,441,995.0	2,330,426.6	-111,568.4	283,867.0	278,596.7	-5,270.2	1,764,814.1	1,720,277.5	-44,536.7
АУРСГАЛ ЗАРЛАГА	6,919,116.9	6,613,809.1	-305,307.9	5,212,459.9	4,993,050.2	-219,409.6	1,909,158.3	1,853,001.5	-56,156.9	283,867.0	278,596.7	-5,270.2	1,761,811.0	1,717,364.0	-44,447.0
1. Бараа, үйлчилгээний зардал	3,300,505.8	3,133,269.5	-167,236.3	2,085,086.7	1,951,042.8	-134,043.9	1,359,860.5	1,323,768.8	-36,091.7	0.0	0.0	0.0	19,247.9	18,896.5	-351.3
1.1. Цалин, хөлс	1,763,559.8	1,746,794.8	-16,765.1	977,751.4	968,555.0	-9,196.4	771,871.2	764,377.3	-7,493.9	0.0	0.0	0.0	13,937.2	13,882.5	-54.7
1.2. Нийгмийн даатгалын шимтгэл, хураамж	163,689.3	160,438.7	-3,250.6	76,213.8	74,635.2	-1,578.6	85,913.0	84,317.3	-1,595.7	0.0	0.0	0.0	1,562.5	1,486.1	-76.4
1.3. Бараа, үйлчилгээний бусад зардал	1,536,945.9	1,386,474.7	-150,471.2	1,031,121.5	907,852.6	-123,268.9	502,076.3	475,074.2	-27,002.1	0.0	0.0	0.0	3,748.1	3,547.9	-200.2
2. Хүү	1,047,885.4	986,119.6	-61,765.8	987,218.4	926,351.4	-60,867.0	0.0	0.0	0.0	60,667.0	59,768.1	-898.8	0.0	0.0	0.0
3. Татаас ба урсгал шилжүүлэг	2,570,725.8	2,494,420.0	-76,305.8	2,140,154.7	2,115,656.0	-24,498.7	549,297.8	529,232.7	-20,065.2	223,200.0	218,828.6	-4,371.4	1,742,563.2	1,698,467.4	-44,095.7
3.1. Татаас	256,916.1	229,325.3	-27,590.9	573,020.4	571,958.8	-1,061.6	86,238.4	84,645.9	-1,592.5	0.0	0.0	0.0	92,536.4	67,599.6	-24,936.8
3.2. Урсгал шилжүүлэг	2,313,809.7	2,265,094.8	-48,714.9	1,567,134.3	1,543,697.2	-23,437.1	463,059.5	444,586.8	-18,472.7	223,200.0	218,828.6	-4,371.4	1,650,026.8	1,630,867.8	-19,159.0
Б. ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	2,412,199.9	2,360,210.2	-51,989.7	1,909,010.5	1,893,336.7	-15,673.8	500,186.3	463,960.0	-36,226.3	0.0	0.0	0.0	3,003.1	2,913.5	-89.6
1. Дотоод эх үүсвэрээр	2,412,199.9	2,360,210.2	-51,989.7	1,909,010.5	1,893,336.7	-15,673.8	500,186.3	463,960.0	-36,226.3	0.0	0.0	0.0	3,003.1	2,913.5	-89.6
1. Барилга байгууламж	1,491,081.4	1,576,950.9	85,869.5	1,227,362.9	1,319,987.8	92,624.8	263,603.4	256,890.3	-6,713.0	0.0	0.0	0.0	115.1	72.8	-42.3
2. Иж засвар	139,765.6	129,004.7	-10,760.9	50,768.0	46,164.4	-4,603.6	87,954.9	81,835.5	-6,119.4	0.0	0.0	0.0	1,042.7	1,004.8	-37.9
3. Хөрөнгийн бусад зардал	469,775.2	401,482.3	-68,292.9	319,301.8	274,412.2	-44,889.6	148,628.1	125,234.2	-23,393.8	0.0	0.0	0.0	1,845.3	1,835.9	-9.4
5. Төсвөөс эргэн төлөгдөх хөрөнгө оруулал	311,577.8	252,772.3	-58,805.5	311,577.8	252,772.3	-58,805.5	0.0	0.0	0.0	0.0	0.0	0.0	0.0	0.0	0.0
В. ЭРГЭЖ ТӨЛӨГДӨХ ЦЭВЭР ЗЭЭЛ	660,836.2	521,313.6	-139,522.7	628,185.9	507,848.5	-120,337.4	32,650.4	13,465.1	-19,185.3	0.0	0.0	0.0	0.0	0.0	0.0
1. Эргэж төлөгдөх дотоод цэвэр зээл	632,513.6	487,553.2	-144,960.4	601,526.5	474,462.4	-127,064.2	30,987.1	13,090.9	-17,896.2	0.0	0.0	0.0	0.0	0.0	0.0
2. Эргэж төлөгдөх гадаад цэвэр зээл	28,322.6	33,760.4	5,437.7	26,659.4	33,386.1	6,726.8	1,663.3	374.2	-1,289.1	0.0	0.0	0.0	0.0	0.0	0.0

Хавсралт №3

/сая төгрөгөөр/

МОНГОЛ УЛСЫН 2016 ОНЫ НЭГДСЭН ТӨСВИЙН ТЭНЦЭЛ

ҮЗҮҮЛЭЛТ	Нэгдсэн			Улсын			Орон нутгийн			ХХС			НДС		
	Төлөв	Гүйц	Зөрүү	Төлөв	Гүйц	Зөрүү	Төлөв	Гүйц	Зөрүү	Төлөв	Гүйц	Зөрүү	Төлөв	Гүйц	Зөрүү
НИЙТ ОРЛОГО БА ТУСЛАМЖИЙН ДҮН	5,429,139.9	5,835,043.8	405,903.9	3,566,591.4	3,894,443.3	327,851.9	2,188,596.8	2,169,796.5	-18,800.3	169,703.4	189,095.1	19,391.6	1,752,427.5	1,809,912.2	57,484.7
НИЙТ ТЭНЦЭВЭРЖҮҮЛСЭН ОРЛОГО БА ТУСЛАМЖИЙН ДҮН	5,429,139.9	5,835,043.8	405,903.9	3,566,591.4	3,894,443.3	327,851.9	2,188,596.8	2,169,796.5	-18,800.3	169,703.4	189,095.1	19,391.6	1,752,427.5	1,809,912.2	57,484.7
НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	9,992,153.1	9,495,332.9	-496,820.2	7,749,656.3	7,394,235.5	-355,420.8	2,441,995.0	2,330,426.6	-111,568.4	283,867.0	278,596.7	-5,270.2	1,764,814.1	1,720,277.5	-44,536.7
НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН - Нийт	-4,563,013.2	-3,660,289.1	902,724.1	-4,183,064.9	-3,499,792.1	683,272.7	-253,398.2	-160,630.1	92,768.1	-114,163.5	-89,501.6	24,661.9	-12,386.6	89,634.7	102,021.4
АЛДАГДЛЫГ САНХҮҮЖҮҮЛСЭН ЭХ ҮҮСВЭР:	4,563,013.2	3,660,289.1	-902,724.1	4,183,064.9	3,499,792.1	-683,272.7	253,398.2	160,630.1	-92,768.1	114,163.5	89,501.6	-24,661.9	12,386.6	-89,634.7	-102,021.4
1. Харилцах болон хадгаламжийн дансны цэвэр өөрчлөлт	256,722.7	-112,351.4	-369,074.0	-12,386.7	-203,240.2	-190,853.6	216,842.0	95,716.3	-121,125.7	39,880.6	84,807.3	44,926.7	12,386.6	-89,634.7	-102,021.4
3. ЗГ-ын бонд	2,941,749.8	3,332,685.0	390,935.2	2,866,018.3	3,281,968.8	415,950.6	0.0	0.0	0.0	0.0	50,716.2	-25,015.4	0.0	0.0	0.0
3.1. Урт хугацаат	2,839,749.8	3,332,766.2	493,006.4	2,764,018.3	3,282,040.0	518,021.7	0.0	0.0	0.0	0.0	50,716.2	-25,015.4	0.0	0.0	0.0
3.1.1. Дотоод	1,818,349.8	2,311,511.2	493,161.4	1,742,618.3	2,260,795.0	518,176.7	0.0	0.0	0.0	0.0	50,716.2	-25,015.4	0.0	0.0	0.0
3.1.1.1. Шинээр гаргах	5,277,088.2	3,754,214.2	-1,522,874.0	4,967,672.8	3,526,137.4	-1,441,535.5	0.0	0.0	0.0	309,415.4	228,076.8	-81,338.6	0.0	0.0	0.0
3.1.1.2. Шинсэн төлбөр	-3,356,738.4	-1,300,415.2	2,056,323.2	-3,123,054.6	-1,123,054.6	2,000,000.0	0.0	0.0	0.0	-233,683.8	-177,360.6	56,323.2	0.0	0.0	0.0
3.1.1.3. Худалдаж авах	-102,000.0	-142,287.8	-40,287.8	-102,000.0	-142,287.8	-40,287.8	0.0	0.0	0.0	0.0	0.0	0.0	0.0	0.0	0.0
3.1.2. Гадаад	1,021,400.0	1,021,245.0	-155.0	1,021,400.0	1,021,245.0	-155.0	0.0	0.0	0.0	0.0	0.0	0.0	0.0	0.0	0.0
3.1.2.1. Шинээр гаргах	1,021,400.0	1,021,245.0	-155.0	1,021,400.0	1,021,245.0	-155.0	0.0	0.0	0.0	0.0	0.0	0.0	0.0	0.0	0.0
3.2. Богино хугацаат	102,000.0	-71.2	-102,071.2	102,000.0	-71.2	-102,071.2	0.0	0.0	0.0	0.0	0.0	0.0	0.0	0.0	0.0
3.2.1. Дотоод	102,000.0	-71.2	-102,071.2	102,000.0	-71.2	-102,071.2	0.0	0.0	0.0	0.0	0.0	0.0	0.0	0.0	0.0
3.2.1.1. Шинээр гаргах	319,600.0	282,754.4	-36,845.6	319,600.0	282,754.4	-36,845.6	0.0	0.0	0.0	0.0	0.0	0.0	0.0	0.0	0.0
3.2.1.2. Шинсэн төлбөр	-217,600.0	-282,825.5	-65,225.5	-217,600.0	-282,825.5	-65,225.5	0.0	0.0	0.0	0.0	0.0	0.0	0.0	0.0	0.0
4. ЗГ-ын зээл	1,365,989.4	1,485,977.3	119,987.9	1,329,433.3	1,421,063.5	91,630.3	36,556.2	64,913.8	28,357.6	0.0	0.0	0.0	0.0	0.0	0.0
4.1. Дотоод	285,766.3	271,534.0	-14,232.3	285,766.3	271,534.0	-14,232.3	0.0	0.0	0.0	0.0	0.0	0.0	0.0	0.0	0.0
4.1.1. Монголбанк (ОУВС)	0.0	0.0	0.0	0.0	0.0	0.0	0.0	0.0	0.0	0.0	0.0	0.0	0.0	0.0	0.0
4.1.1.1. Шинээр гаргах	200,000.0	200,000.0	0.0	200,000.0	200,000.0	0.0	0.0	0.0	0.0	0.0	0.0	0.0	0.0	0.0	0.0
4.1.1.2. Үндсэн төлбөр	-200,000.0	-200,000.0	0.0	-200,000.0	-200,000.0	0.0	0.0	0.0	0.0	0.0	0.0	0.0	0.0	0.0	0.0
4.1.2. Авлага	-25,811.5	18,761.7	44,573.2	-25,811.5	18,761.7	44,573.2	0.0	0.0	0.0	0.0	0.0	0.0	0.0	0.0	0.0
4.1.2.1. Үндсэн төлбөр	-25,811.5	18,761.7	44,573.2	-25,811.5	18,761.7	44,573.2	0.0	0.0	0.0	0.0	0.0	0.0	0.0	0.0	0.0
4.1.3. Төсвөөс эргэн төлөгдөх	311,577.8	252,772.3	-58,805.5	311,577.8	252,772.3	-58,805.5	0.0	0.0	0.0	0.0	0.0	0.0	0.0	0.0	0.0
4.1.3.1. Авлах	311,577.8	252,772.3	-58,805.5	311,577.8	252,772.3	-58,805.5	0.0	0.0	0.0	0.0	0.0	0.0	0.0	0.0	0.0
4.2. Гадаад	1,080,223.1	1,214,443.3	134,220.2	1,043,667.0	1,149,529.5	105,862.5	36,556.2	64,913.8	28,357.6	0.0	0.0	0.0	0.0	0.0	0.0
4.2.1. Төслийн зээл	468,223.1	626,939.6	158,716.5	431,667.0	562,025.8	130,358.8	36,556.2	64,913.8	28,357.6	0.0	0.0	0.0	0.0	0.0	0.0
4.2.1.1. Шинээр авах	623,286.5	762,554.3	139,267.8	586,730.4	697,640.5	110,910.2	36,556.2	64,913.8	28,357.6	0.0	0.0	0.0	0.0	0.0	0.0
4.2.1.2. Үндсэн төлбөр	-155,063.4	-135,614.7	19,448.7	-135,063.4	-135,614.7	19,448.7	0.0	0.0	0.0	0.0	0.0	0.0	0.0	0.0	0.0
4.2.2. Хөтөлбөрийн болон төслийн бус	612,000.0	587,503.7	-24,496.3	612,000.0	587,503.7	-24,496.3	0.0	0.0	0.0	0.0	0.0	0.0	0.0	0.0	0.0
4.2.2.1. Шинээр авах	612,000.0	587,503.7	-24,496.3	612,000.0	587,503.7	-24,496.3	0.0	0.0	0.0	0.0	0.0	0.0	0.0	0.0	0.0
5. Урьдчилгаа төлбөрөөс улсын төсөвт тооцогдсон	25,811.5	-18,761.7	-44,573.2	0.0	0.0	0.0	0.0	0.0	0.0	25,811.5	-18,761.7	-44,573.2	0.0	0.0	0.0
6. Урьдчилгаа төлбөрөөс тооцогдсон	-27,260.2	-27,260.2	0.0	0.0	0.0	0.0	0.0	0.0	0.0	0.0	-27,260.2	0.0	0.0	0.0	0.0
8. ЗГ-ын хөрөнгө оруулалт	0.0	-1,000,000.0	-1,000,000.0	0.0	-1,000,000.0	-1,000,000.0	0.0	0.0	0.0	0.0	0.0	0.0	0.0	0.0	0.0



МОНГОЛ УЛСЫН
ЕРӨНХИЙ АУДИТОРЫН
ТУШААЛ

2017 оны 06 сарын 05 өдөр

Дугаар А/106

Улаанбаатар хот

Аудитын тайланг баталгаажуулах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.4.5, 13.4.7 дахь заалт, 15 дугаар зүйлийн 15.1.7 дахь заалт, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.10.2 дахь заалтыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. "Монгол Улсын 2016 оны нэгдсэн төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан"-г нэгдүгээр хавсралтаар, "Аудитаар тогтоосон төлбөрийн актын жагсаалт"-ыг хоёрдугаар хавсралтаар тус тус баталсугай.

2. Аудитын тайланг Улсын Их Хурал, Засгийн газар, Сангийн яаманд хүргүүлсүгэй.

3. Аудитаар өгсөн зөвлөмжүүдийг хэрэгжүүлэх арга хэмжээ авч, үр дүнг 2017 оны 12 дугаар сарын 10-ны дотор Үндэсний аудитын газарт ирүүлэхийг Монгол Улсын Ерөнхий сайд, Сангийн сайд нарт зөвлөсүгэй.

4. Аудитын тайланд тусгагдсан зөвлөмж, актын хэрэгжилтэд хяналт тавьж, үр дүнг тооцож ажиллахыг Санхүүгийн аудитын газар /Ц.Наранчимэг/-т үүрэг болгосугай.

МОНГОЛ УЛСЫН
ЕРӨНХИЙ АУДИТОР



Д.ХҮРЭЛБААТАР

\\10.10.10.20\Bichig_Kheregi\Tushaal\2017\0605SAG4docx.Docx

070451

